

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.020.50

<p>Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл- Байгаль орчны мэдэгдэл - III загвар. Техникийн Тайлан</p> <p>Environmental labels and declaration - Type III environmental declarations.</p> <p>Technical Report</p>	<p>MNS ISO/TR 14025:2001</p>
--	-------------------------------------

Стандартчилал, хэмжил зүйн төвийн Зөвлөлийн 2001 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 73-р тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2002 оны 01 дугаар сарын 01-ээс эхлэн хүчинтэй.

Энэ стандарт нь зөвлөмжийн шинжтэй байна.

1. Хамрах хүрээ

Техникийн тайлан нь III загварт хамаарах байгаль орчны мэдэгдэл, холбогдох хөтөлбөрийн талаархи асуудал ба түүний бүрдэл хэсгийг тогтоож тодорхойлохтой холбогдсон техникийн асуудал, тухайлбал тунхаглах хэлбэр, уялдаа холбоо, уг мэдэгдлийг боловсруулах, батлах талаархи удирдлага, зохион байгуулалтын асуудлыг тус тус анхааран үзнэ.

2. Норматив ишлэл

Дараахь норматив баримт бичиг нь энэхүү Техникийн тайлангийн загвар, агуулгыг хянахад лавлагаа болж өгнө. Он сар өдөр заасан лавлагаа, нэмэлт өөрчлөлт оруулсан, сэргээж засварласан төслийн хувилбарын алиныг ч үүнд хэрэглэхгүй. Хэдий тийм боловч, хэлэлцээр байгуулагч талууд энэхүү Техникийн тайланг үндэслэл болгох, зөвшөөрөл олгох үед дор дурдсан стандартын хамгийн сүүлийн үеийн хэвлэлийг ашиглах боломж бий эсэхийг судлахад дэмжлэг болно. Дээрх лавлагаа болон нэгэнт хэвлэсэн норматив баримт бичгийн хувьд бол хамгийн сүүлийн үеийн хэвлэлийг хамааруулна. ОУСБ ба ОУЦТК-ын гишүүд одоо хүчинтэй байгаа Олон улсын стандартын бүртгэлийг хариуцан хийнэ.

MNS ISO 14020:1998, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл - Ерөнхий зарчим.

MNS ISO 14021:1999, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл - Байгаль орчны талаархи мэдүүлэг (Байгаль орчны эко-тэмдэг хэрэглэх II загвар).

MNS ISO 14024:1999, Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл - Байгаль орчны Эко-тэмдэг – Зарчим ба журам

MNS ISO 14040:1997, Байгаль орчны менежмент – “Амьдрал”-ын мөчлөг – Бүтэц ба зарчим

MNS ISO/TR 14025 : 2001

ISO 14041 :1998, Байгаль орчны менежмент – “Амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээ-Зорилго, хамрах хүрээний тодорхойлолт болон задлан шинжилгээний цэс (инвентар анализ)

ISO 14042 : 2000, Байгаль орчны менежмент(удирдлага) - Амьдралын мөчлөгийн үнэлгээ- - “Амьдрал”-ын мөчлөгийн туршид үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

ISO 14043 : 2000, Байгаль орчны менежмент - Амьдралын мөчлөгийн үнэлгээ-- Амьдралын мөчлөгийн утгыг нь тайлбарлах(interpretation) буюу тодорхойлох

3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү Техникийн тайлангийн зорилт нь ISO 14020; ISO 14024; ISO 14040; ISO 14041; ISO 14042; ISO 14043-д дурдсан нэр томъёо, тодорхойлолтыг дараахь байдлаар ашиглана.

3.1

ангилалын төгсгөл

Байгаль орчны асуудалд байгаль орчин, хүний эрүүл мэнд ба нөөц баялгийг хамааруулан авч үзэх

Тайлбар: 2-р зураг[ISO 14042:2000]-т энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлах болно

[ISO 14042:2000]

3.2

баталгаажуулалт

бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ нь тодорхой шаардлагыг хангасан эсэх талаар хөндлөнгийн байгууллагаас бичгээр баталгаа өгөх үйл ажиллагаа.

[ОУСБ/ ОУЦТК-ын Арга зүйн 2 тоот заавар : 1996]

3.3

үүрэг ажиллагааны нэгж

“амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээний судлагааны үед лавлагааны нэгж болгон ашиглахад зориулсан бүтээгдэхүүний тогтолцооны гүйцэтгэлийн тоон илэрхийлэл,

[ISO 14040:1997]

3.4

нөлөөллийг ангилах

Амьдралын мөчлөгийн үзүүлэх нөлөөллийн үр дүнд ямар дүгнэлт ашиглахыг тогтоох талаар байгаль орчны асуудлын зэрэглэл(ангилал)

[ISO 14042:2000]

3.5

сонирхогч талууд

Байгаль орчны мэдэгдэлд хамаарах III дахь загварын ашиглалт болон хэрэгжилтэд нөлөө үзүүлж буй аливаа сонирхогч байгууллага буюу бусад этгээд.

3.6

Амьдралын мөчлөгийн нөлөөлөлд ангилал тогтоох заагч(индикатор)

Нөлөөллийн зэрэглэлийн тоон утгын илэрхийлэл.

Тайлбар: Тайлбарыг ойлгомжтой болгохын тулд “зэрэглэл тогтоох заагч” гэсэн товчилсон хэллэгийг энэхүү стандарт(нэр томъёо болон тодорхойлолтыг хамруулан)-д ашигласан болно.

[ISO 14042:2000]

3.7

бүтээгдэхүүн

аливаа бүтээгдэхүүн болон үйлчилгээ

[ISO 14024:1999]

3.8

бүтээгдэхүүний ангилал

адил төстэй үүрэг ажиллагаа(шинж чанар)-тай бүтээгдэхүүний бүлэг

[ISO 14024:1999]

3.9

бүтээгдэхүүний үзүүлэлтийн үүрэг (функци)

бүтээгдэхүүний хэрэглээний буюу ашиглалтын үзүүлэлт, эсвэл онцлог шинж

[ISO 14024:1999]

3.10

гурав дахь тал буюу хөндлөнгийн оролцогч этгээд

бие даасан хэсэг болохыг хүлээн зөвшөөрсөн, тавьж буй асуудалтай холбогдуулан татан оролцуулах байгууллага буюу хувь хүн.

Тайлбар: “Гуравдагч тал буюу хөндлөнгийн оролцогч этгээд” гэдэгт баталгаажуулалтын байгууллагыг заавал хамааруулан ойлгох шаардлагагүй.

3.11

Байгаль орчны мэдэгдлийн III загвар

ISO 14040 стандартад үндэслэн урьдчилсан үнэлгээг холбогдох бүтээгдэхүүнд хийж, байгаль орчны талаархи өгөгдлийг тооцоолж гаргана. Гэхдээ байгаль орчны мэдэгдлийн III загварт хамаарах хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны холбогдолтой нэмэлт мэдээллийг багтаавал зохино.

Тайлбар: Танилцуулж буй байгаль орчны мэдэгдлийн III загварт хувилбар арга зүйг бодолцож үзэх хэрэгтэй. Цаашдын стандартчиллын ажил, хувилбар арга зүй хоёр нь нийцэж, байгаль орчны мэдэгдлийн III загварын үндэслэл нь болно. Иймээс энэ Техникийн тайланг хэлэлцэж хэрэглэхдээ арга зүйн холбогдох асуудлын талаар ч мөн авч хэлэлцвэл зохино. Алс хэтдээ шинэ стандарт боловсруулах явцад энэ талаар арга зүйн өөр хандлагыг хэрэглэхэд хүрвэл үүнийг нэгтгэж болно.

3.12

Байгаль орчны мэдэгдлийн III загварт хамаарах хөтөлбөр

MNS ISO/TR 14025 : 2001

Үйлдвэрлэлийг буюу бие даасан байгууллагыг хөгжүүлэхэд шаардлагын доод хэмжээг тогтоож, магадлуурын ангилал(зэрэглэл)-ыг сонгохыг оролцуулан хөндлөнгийн оролцогч талыг тодорхойлон, гаднын холбоо харилцааг бүрдүүлж өгөх асуудлыг багтааж тусгасан - Байгаль орчны мэдэгдлийн III загварын хувилбар дэвшүүлж байгаа сайн дурын ажиллагаа.

4. Байгаль орчны мэдэгдлийн III загварын зорилго

Байгаль орчны эко-тэмдэг, мэдэгдлийн зорилго нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар байгаль орчны холбогдолтой үнэн зөв мэдээллийн туслалцаатай түүнд сөрөг нөлөө бага үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нийлүүлэлтийг сайжруулж, ингэснээр зах зээлийн жолоодлоготой, байгаль орчны тэнцвэртэй байдлыг байнга хадгалан хөгжүүлэхэд оршино.

[ISO 14020]

5 Техникийн шаардлага

5.1 Ерөнхий зүйл

ISO 14020-ийн зарчмын дагуу байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулахдаа уг мэдэгдэлд багтсан мэдээлэл буюу байгаль орчны холбогдол бүхий асуудлыг үнэн зөв гарган холбож өгөх чадвартай шинжлэх ухааны болон инженерчлэлийн арга зүйд үндэслэсэн байна. Энэхүү Техникийн тайлан нь байгаль орчны мэдэгдлийн III загварыг хэрэгжүүлэх талаар практик ажиллагаа дахь туршлага, мэдээллийг илтгэж харуулна.

Тодруулбал, Байгаль орчны мэдэгдлийн III загварт хамаарах онцлог асуудлыг тогтооно. Үүнд:

- Тоо баримт цуглуулах талаархи арга зүй, түүнийг үнэлэх (үнэлгээ буюу зорилгыг хамааран үзэх) (5.2);
- Амьдралын мөчлөгийг шинжлэх цэс(АМШЦ)-ийн өгөгдлийг болон амьдралын мөчлөгийн нөлөөллийн үнэлгээ (АМНҮ) -г ангилан сонгох (5.3, 7.2);
- Байгаль орчны талаархи мэдээллийн чанарыг хангах, нарийвчлал, тодорхой бус байдлыг үнэн зөв тодорхойлох (5.2.3, 5.5);
- Байгаль орчны холбогдолтой мэдээлэл мөн эсэхийг будлиангүй тогтоох (6, 7.2 дугаар зүйл);
- Гол худалдан авагчидтай харилцаа холбоотой байх (7 дугаар зүйл);
- олон улсын хэмжээнд тодорхой бүтээгдэхүүний чанараар өрсөлдөх чадвар, техникийн түвшингийн харьцуулалт, хэрэглээний холбогдолтой хангалттай мэдээлэл бүрдүүлнэ.

5.2 Арга зүйн сонголт

5.2.1 Ерөнхий зүйл

Байгаль орчны мэдэгдлийн III загварт багтаж буй бүтээгдэхүүний холбогдолтой байгаль орчны мэдээлэл нь ISO 14040 стандартын дагуу түүний амьдралын мөчлөгийн талаархи судалгааны явц, үр дүнд үндэслэсэн байна. Байгаль орчны мэдэгдлийн III загвар нь өдийг хүртэл тухайн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн тухай илэрч байгаа мэдээлэл, мөн түүний үнэлгээ(АМҮ)-г ашиглан арга зүйн асуудалд үндэслэсэн байна. ISO 14040 стандартад хамаарч буй энэ зүйл байгаль

орчны мэдэгдлийн III загвар ба төлөвлөлтийн арга зүйн хувилбар сонголтыг тодорхойлж өгнө. 1-р зураг дээр төрөл бүрийн хувилбарын уялдаа холбооны талаар зааж үзүүлсэн болно. Эдгээр стандартын нийтлэг элемент буюу ижил төстэй талын хувилбар бүрийг нь ISO 14040; ISO 14041; ISO 14043 стандартын дагуу “амьдрал”-ын мөчлөгийн нөлөөлөл(AMH)-д үндэслэсэн байна. Харин мэдэгдлийн сүүлчийн шатанд 1-р зураг дээр үзүүлсэнчлэн өөр өөр хэсэг болон салаалдаг байна.

- **А.Сонголт:** “Амьдрал”-ын мөчлөгийн шинжлэх цэс-AMШЦ(Амьдралын мөчлөгийн нөлөөлөл(AMH) нь ISO 14040+ ISO 14041+ ISO 14043 стандартын дагуу), эсвэл
- **Б.Сонголт:** AMH-г “амьдрал”-ын мөчлөгийн нөлөөний үнэлгээ(AMHY)-ээс урган гарах (AMHY нь ISO 14040+ ISO 14041+ ISO 14043 стандартын дагуу), эсхүл
- **С.Сонголт:** AMH-г ISO 14040+ ISO 14041 + ISO 14043 стандарт мөн зарим өгөгдлийн дагуу, харин заавал ISO 14042 стандартын дагуу байх шаардлагагүй.(хувилбар-арга зүйтэй холбогдуулан)

Байгаль орчны талаархи задлан шинжлэх бусад арга хэрэгсэл нь III загварт тодорхой дэмжлэг болохоор нэмэлт мэдээлэл болж өгнө. (1-р зураг үзнэ үү). Байгаль орчны талаархи нэмэлт мэдээллийг энд заавал багтаавал зохино. Уг мэдээлэл нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгт үндэслэсэн, эсвэл хамааралгүй байж болно. Энэ нь ерөнхийдөө, байгаль орчинд бүтээгдэхүүний үзүүлэх нөлөөлөл бүхий холбоотой асуудлыг хөндсөн байх бөгөөд эдийн засаг, нийгмийн гэх зэрэг тогтвортой хөгжлийн элементийг багтаасан байна.

Байгаль орчны мэдэгдлийн III загварт багтаасан эдгээр арга зүйн болон бусад холбогдох асуудлын талаар **А.хавсралтад** дурдсан болно.

5.2.2 Бүтээгдэхүүний харьцуулалтад анхаарах зүйл


Техникийн тайлангийн тодорхойлолтыг 3.11-т тайлбарласанчлан байгаль орчны мэдэгдлийн III загварын гол зорилго нь байгаль орчны тухай тоо баримтын өгөгдлөөр хангахад оршино. Хэдийгээр байгаль орчны мэдэгдлийн III загварт харьцуулалтын магадлал байдаггүй ч, түүний мэдээллийг ашиглан бүтээгдэхүүнийг хооронд нь харьцуулах боломжтой. Байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулагчид AMHY-ний “харьцуулсан магадлал” болон ISO 14040 стандартын шаардлагыг анхаарч, техникийн ямар аргад тулгуурласан ч арга зүйг боловсруулах үед тэдгээрийг удирдамж болгон ашиглах хэрэгтэй.

5.2.3 Шүүмжлэлийг задлан шинжлэх

Шүүмжлэлийг задлан шинжлэх талаар AMY-ний судалгааны арга нь ISO 14040, ISO 14041, ISO 14042, ISO 14043 тоот олон улсын стандартад нийцэж буй эсэхийг хянана. Үнэлгээ нь ISO 14040: 1997 тоот стандартын 7.3.3 дугаар зүйлд заасан шүүмжлэлийн задлан шинжилгээтэй зохицсон байна. Уг шүүмжлэлийн задлан шинжилгээний ажил нь AMHY-г тогтоож ашиглахаар зэхэж буй арга зүй нь шинжлэх ухааны болон техникийн хувьд батлагдсан, хүчин төгөлдөр үү, энэ талаар хуримтлуулсан өгөгдөл нь судалгааны зорилго, хамрах хүрээндээ нийцсэн үү, хязгаарлагдмал байдал тогтоож тусгасан эсэх, уг тайланг шилжүүлэх үү, эсвэл хадгалан тогтвортой байлгах уу гэдгийг тус тус тодорхойлно. Техникийн тайлангийн

MNS ISO/TR 14025 : 2001

хувьд хувилбар арга зүйг дүгнэхэд шүүмжлэлийн задлан шинжилгээг ашиглана. Байгаль орчны мэдэгдлийн III загварын бүх хэлбэрт шүүмж хийхдээ гадны харилцаа холбооны хамрах хүрээ, агуулга, энэ нь эцсийн хэрэглэгчдэд хэрхэн хүрэх талаархи дүгнэлтийг багтаасан байх хэрэгтэй. Энэ дүгнэлтэд ISO 14020 стандарт болон хөтөлбөрийн ажиллагааны чиг шугамыг баримталсан эсэх талаар тавьсан хяналтыг хамруулсан байвал зохино.



Тайлбар: А.1.2, А.1.3, А.2 ыг үзнэ үү.

1-р зураг — Байгаль орчны мэдэгдлийн III загвар болон хөтөлбөрийн гурван ялгаа бүхий хувилбар арга зүй

5.3 Параметр(магадлуур)-ийн урьдчилсан зэрэглэл

5.3.1 Байгаль орчны мэдэгдлийн III загварын магадлуурын урьдчилсан зэрэглэлийг тогтоох

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хэрэглээний бүх хэлбэрийн янз бүрийн шатны хувьд бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн магадлуурын урьдчилсан зэрэглэлийн бүрдүүлэлт, харьцуулалт, бүрэлдэхүүнийг хянах шаардлагатай гэж үзэж буй магадлуурын урьдчилсан зэрэглэл нь бүх бүтээгдэхүүн дээр адилхан байх албагүй. Ашигласан арга зүйгээс хамааралгүйгээр ISO 14042 : 2000 стандартын 5.3 дугаар зүйл нь магадлуурын урьдчилсан зэрэглэлийг адилтгах талаар зааварчлагааг хангана(ISO 14042 тоот стандартад “нөлөөллийн ангилал” ба “зэрэглэл заагч буюу индикатор” гэж иш татаж хэрэглэсэн.)

5.3.2 Магадлуурын урьдчилсан зэрэглэлийг тогтоох хувилбар

Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тогтолцооны магадлуурын тохиромжтой урьдчилсан зэрэглэлийг тогтооход хэд хэдэн хувилбарыг анхаарч үзэх буюу хэрэглэх болно. Эдгээр хувилбарын тохирох арга зүйг хэрхэн сонгох нь цаашдын стандартад чухал нөлөө үзүүлнэ. Цаашид батлах стандартад тохирох хувилбар нь:

- Бүх төрлийн бүтээгдэхүүнд тохирох нэг бүлэг магадлуурын урьдчилсан зэрэглэлийг тогтоох;
- Магадлуурын урьдчилсан зэрэглэлийн хамгийн доод хязгаарыг тогтоох, үүний хамт онцлог тухайн бүтээгдэхүүний болон санал хүсэлт тавигчдийн шаардлагад нийцэхүйц нарийвчилсан үнэлгээний хувилбарыг тайлбарлаж хавсралт мэдээлэл гаргах;
- Үнэлгээний гол гол урьдчилсан зэрэглэлийн жагсаалт гаргаж, ямар арга зүйг сонгож, зэрэглэх талаар зөвлөлдөх;
- Бүх төрлийн бүтээгдэхүүний холбогдолтой ашиглаж болох магадлуурын урьдчилсан зэрэглэлийн хамгийн товч хувилбарыг тогтоох бололцоо олгох, үүний хамт олон янзын бүтээгдэхүүний тогтолцооны тодорхой нэр төрөлд тохирох үнэлгээний зэрэглэлийн нэмэлтийг хавсаргах.

5.3.3 Жишээ

Байгаль орчинтой холбогдуулан бүтээгдэхүүний тогтолцоог судлахад АМНУ-г ашиглах тул магадлуурын урьдчилсан зэрэглэл нь ISO 14041 стандартын АМНУ-ий судалгааны үр дүнд үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний тогтолцооноос гарч буй болон түүнд шингэж буй материал, эрчим хүчний эргэлт. “Амьдрал”-ын мөчлөгийн нөлөөлөх байдлын үнэлгээ(АМНБҮ)-ний хувьд үр дүн нь ISO 14042 тоот стандартад заасан зэрэглэлийн шинж чанарын мэдээлэл байна. Цаашдын алхам нь сонгож авсан магадлуурын зэрэглэлийн талаархи цаг хугацааны өөрчлөлтийг тогтмол зохицуулах болон сайжруулахаар журам тогтооход чиглэнэ.

MNS ISO/TR 14025 : 2001

ISO ийн хүрээнд Техникийн тайлан хоёрыг боловсруулж байна. Энэ нь ISO 14041 (өөрөөр хэлбэл ISO/TR 14049) ба ISO 14042 (ө. х ISO/TR 14047)-ийг хэрхэн хэрэгжүүлэх талаар ишлэл хэрэглэсэн тайлбартай.

Магадлуурын урьдчилсан зэрэглэлийн жишээг А.1.4 -т үзүүлсэн.

5.4 Байгаль орчны талаархи нэмэлт мэдээлэл

Байгаль орчны мэдэгдлийн III загварын гол цогц заагч(индикатор)-аас гадна байгаль орчны талаар нэмэлт мэдээлэл байх ёстой. Ерөнхийдөө, энэхүү мэдээлэл нь байгаль орчинд тухайн бүтээгдэхүүний үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой байна. Энэ урьдчилсан нөхцлийн дор байгаль орчны талаар хэд хэдэн төрлийн нэмэлт мэдээлэл авч байна. Үүнд:

- Амьдралын мөчлөгийн үнэлгээ(AMУ)-ээс үүдэн гарсан, гэхдээ Амьдралын мөчлөгийн нөлөөлөл(AMН), эсвэл Амьдралын мөчлөгийн нөлөөллийн үнэлгээ(AMНУ)-нд тулгуурласан маяг хэлбэрт хамаарахгүй мэдээлэл, өөрөөр хэлбэл дахин боловсруулагдах материалын бүтэц буюу чадамж гэх мэт;
- Бүтээгдэхүүний AMУ-ний судалгаатай холбогдолгүй, гэвч түүний амьдралын мөчлөг болон байгаль орчны талаархи мэдээллийн зарим хэсэг дээр үндэслэсэн мэдээлэл (даавууны бүтэц, пестицидийн нэр төрлийн хорт бодис г. м.);

Байгаль орчны талаархи эдгээр нэмэлт мэдээллийг шүүмжлэл, хяналт тавих зэргээр өөрчилж болохуйц байх хэрэгтэй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийг тусгаагүй, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай заавар, мэдээлэл нь Байгаль орчны мэдэгдлийн III загварын хэсэг биш, харин ерөнхий чиглэл болж өгөх ёстой. (жишээлбэл: зөв зохистой ашиглах, анхан шатны арга хэмжээ, хаяж булшлах талаар зааварчлага)

5.5 Чанарын баталгаа (мэдээллийн өгөгдөл ба урьдчилсан хэлбэр)

Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулан цуглуулж, илтгэсэн шинжлэх ухаан, техникийн мэдээлэл нь чанарын хувьд хангалттай, бодит баталгаатай байх ёстой.

Практик ажиллагаанд AMУ буюу хувилбар арга зүйгээс үүдэн мэдээлэл нь хэмжиж, тооцоолж, үнэлсэн өгөгдлийн цогцод тулгуурласан байна. Байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулахад ашигласан өгөгдлийн чанар нь түүний хэрэглэх боломж, олдоц, эсвэл оноцтой байдал, нарийвчлал(тухайлбал өгөгдлийн уялдаа холбоо, төрөл г.м)-аас шалтгаална. AMУ, эсвэл хувилбар арга зүйн холбогдох өгөгдөл нь наад зах нь дараахь шаардлагуудад чиглэсэн байх ёстой. ISO 14041:1998 тоот стандартын 5.3.6-д энэ талаар нарийн тайлбарласан.

- Өгөгдөл цуглуулах арга зүйн үр дүнгийн таарц болон дахин боловсруулагдах чадамж;
- Газар зүйн хамаарал;

- Өгөгдлийн нарийвчлал, бүрэн бүтэн болон нийтлэг шинж;
- Өгөгдлийн эх сурвалж, түүний нийтлэг зүйл;
- Технологи,
- Цаг хугацааны хамаарал; ба
- Мэдээллийн таамаглал(буюу тодорхой бус байдал).

Өгөгдлийн чанарыг үнэлэхийн зэрэгцээ, үүнийг байгаль орчны мэдэгдлийн III дахь загварт өргөн барьсан мэдээлэл болгон хувиргасан аргын чанарыг нягтлах нь чухал. Судалгааны үр дүнтэй холбоо хамааралтай, ач холбогдолтой эсэхийг мэдэхийн тулд өгөгдлөө цуглуулсны дараа статистик аргаар ангилах, загварчлах, эмхлэн дараалуулж болно (таамаглал, мэдрэмжийн байдал г м). Байгаль орчны мэдэгдлийн III загварын мэдээлэл ташаа эсэхийг тогтооход дээрхи аргыг ашиглаж болно.

6 Сонирхогч талуудын дамжуулалт

6.1 Ерөнхий зүйл

Байгаль орчны мэдэгдлийн III загвар, хөтөлбөрийг боловсруулах ба зохион байгуулах үйл ажиллагаанд сонирхож буй талуудад зориулж нээлттэй зөвлөлгөөн явуулахыг ч багтааж оруулна. Байгаль орчны мэдэгдлийн III загвар, хөтөлбөрийг боловсруулахад сонирхогч талуудын үүрэг ролийн шаардагдах хамрах хүрээг нь анхаарч үзэх хэрэгтэй. Үйл ажиллагааны үед тохиролцоонд хүрэхийн тулд тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй (ISO14020).

Зөвлөлгөөнийг бүтээгдэхүүний ангилал(буюу зэрэглэл), магадлуурын урьдчилсан зэрэглэлийн сонголтын үед явуулдаг бөгөөд бүтээгдэхүүний ангилал бүрийн онцлог шаардлагад тавих магадлуурын холбогдолтой мэдээлэл болон тогтмол хяналтын талаар шаардагдах мэдээллийн журмыг тогтооно.

Тэдгээр нь олон талын зорилготой бөгөөд сонирхогч талуудад таатай нөхцөл, боломжтойгоор дамжуулна. Дамжуулалтыг сонирхогч талуудад тохиромжтой байхаар нөхцөл бүрдүүлэн тэдний онцлог сонирхолыг тусгаж, техникийн хэвлэлээр болон бүхэлд нь хялбар байдлаар итгэл үзүүлэн хангахад чиглэнэ.

ISO 14024 нь сонирхогч талуудын хэвлэлд тусгахтай холбогдуулан бүхэлд нь иш татаж хэрэглэж болно.

6 Сонирхогч талуудад дамжуулахаар төлөвлөсөн үе шат

Байгаль орчны мэдэгдлийн III загварын болон хөтөлбөрийн бүх хэлбэрийн анхны боловсруулалтыг сонирхогч талуудад хүргэх асуудлыг шийдвэрлэх, жишээлбэл, дараахь үе шатыг:

- бүтээгдэхүүний ангилалын сонголт ба тодорхойлолт;
- бүтээгдэхүүнийг ангилалыг тодорхойлоход ашигласан техникийн холбогдолтой задлан шинжилгээний шүүмжийн тойм;

MNS ISO/TR 14025 : 2001

- бүтээгдэхүүний функционал үзүүлэлт(шинж чанар)-ийг тогтоох болон байгаль орчны мэдэгдлийн III загварт уг бүтээгдэхүүний холбогдолтой байгаль орчны мэдээллийн сонголт, боловсруулалт болон сайжруулалт;
- байгаль орчинтой холбогдох бүтээгдэхүүний мэдээлэл(AMУ-ний үр дүн, ISO 14040 : 1997, 7 дугаар зүйл);
- баталгаажуулалт/ мэдээллийн III загвар(хэрэв хэрэглэгдэх бол);
- дотоод харилцааны хэлбэр, түүний агуулгын тодорхойлолт;
- магадлуурын урьдчилсан ангилалын сонголт.

Тохиромжтой дамжуулалтыг хангах үйл явц нь сонирхогч талуудтай зөвлөлдөх хэлбэр, тасралтгүй хөдөлгөөн, дамжлага, оролцогчдын цуглааны нээлтийг хэрхэн яаж зохион байгуулах асуудлыг шийдвэрлэнэ. Дамжуулалтын үе дэх шатыг юунаас ч хангалттай тодорхойлсон, сонирхогч талуудад дамжуулах ажиллагаа дараахь зүйлд чиглэсэн байна. Үүнд:

- ашигласан мэдээлэл болон өгөгдлийн эх сурвалжид холбогдох амжилтыг хангах;
- цаг үеийн албадлагын тохиромжтой задлан шинжилгээг хөхүүлэн урамшуулах;
- цаг үеийн санал, анхааруулгыг шийдвэрлэх;
- хэрэглэгдэх боломжтой газар нь гурав дахь тал(буюу хөндлөнгийн этгээд)-ын хөтөлбөрийн холбогдол бүхий захирамжлалын шаардлага(ISO 14024 : 1999 тоот стандартын 7 дугаар зүйл болон 5.7-оос 5.12; 5.14 -өөс 5.17 хүртэл зүйлд заасан арга зүйн зааврыг үз)-ыг тавих.

6.3 Онцлог-бүтээгдэхүүнд шаардлагатай мэдээллийг тогтоох үзэл баримтлал

Сонирхогч талуудтай зөвлөлдөх явц нь шаардлага, нэгжийг тодорхойлох бөгөөд онцлог-бүтээгдэхүүний магадлуурын ангилалтай холбогдох асуудлыг тайланд ашиглах, бусад элементийг бодолцох, мөн ангилалд хамаарах зарим бүтээгдэхүүнийг байгаль орчны мэдэгдлийн III загвар, харьцуулагдах тохиромжтой байдлын хоорондын уялдаа хамаарлыг хангахад чиглэнэ.

“Амьдрал”-ын мөчлөгийн задлан шинжлэх цэс(инвентарь)-ийн дүнд жишээлбэл, функционал нэгжийн тухай мэдээлэл, тогтолцоо(систем)-ны заагийн хүрээ болон тархалтын дүрмийг оруулна. Харин “амьдрал”-ын мөчлөгийн нөлөөлөх байдлын үнэлгээний үр дүнгээс нь жишээлбэл, ашигласан арга зүйг болон бохирдлыг бууруулах тухай мэдээллийг оруулж болно.

А.1.4-т магадлуурын урьдчилсан ангилалын чадавхийг харуулсан хүснэгт.

6.4 Сонирхогч талуудад чиглэсэн дамжуулалтын хувилбарын боломж

Сонирхогч талуудад чиглэсэн дамжуулалтын хоёр хувилбарыг цаашид стандартаар тогтооно. Үүнд:

- Хэрэглээний хаяг ба гаднын сувгийн талаар нарийвчлан заасан аргачлалаар хангана, эсхүл
- ISO 14040 стандартын шүүмжид ишлэл хэрэглэх ба ISO 14020 стандартын сонирхогч-талуудын дамжуулалттай холбогдсон дүрмийг төвөгтэй биш байдлаар нэгтгэж ашиглана.

7 Мэдэгдлийн маяг хэлбэр, харилцаа холбоо

7.1 Ерөнхий зүйл

Харилцаа холбооны мэдээлэл нь бүтээгдэхүүний ангилал, төлөвлөгөөт үзлэг шалгалтын норматив баримт бичиг ба стандартчилсан аргын дагуу байгаль орчны холбогдолтой мэдээллийг хувиргана. Бүтээгдэхүүний ангилалын суурь мэдээлэлтэй холбогдсон шаардлага, бичлэгийн уялдуулсан зохицуулалтыг сонирхогч талуудтай тохиролцоно. Энэхүү тохиролцоог зөвлөлдөх явцын нээлтийн арга хэмжээний үед уншиж танилцуулна.

Үг, тоо эсвэл тэмдгийг ашиглахаар байгаль орчны бус мэдүүлэгийн зорилгыг тухайн асуудлалд ашиглахгүй гэж байгаль орчны мэдүүлэгийг авах үед ташаа, буруу ойлголцох магадлал байж болно (ISO 14021 : 1999, 5.9.2).

Гадаад харилцаа холбоог байгаль орчны мэдэгдлийн III загвар болон харьцуулалтын тохиромжтой байдлын хоорондын асуудлаар сонирхогч-талуудын зөвлөлгөөнийг нээх ажиллагааны үеэр ерөнхий зарчим, маягтын төрлийг тодорхойлно.

7.2 Хэрэглэгчийн шаардлагатай мэдээллийг тогтоох

Байгаль орчны мэдэгдлийн III загварын маягт, боловсруулалт нь ухаалагаар, эцсийн хэрэглэгчийн шаардлагатай уялдан хөгжинэ. Эдгээр нь эцсийн хэрэглэгчийн янз бүрийн шаардлагаас үүдэн янз бүрийн хувилбарын боломжтой байна. Эдгээр хэрэглэгчдийг хоёр ангилалд хувааж болно: Хэрэглэгч буюу эцсийн хэрэглэгч болон үйлдвэрлэл/ худалдааны эцсийн хэрэглэгч гэж хуваана.

Энэ тохиолдолд, хэрэглэгч буюу эцсийн хэрэглэгч бол байгаль орчны мэдэгдлийн III загварыг сайжруулдаг, түүний бүх талын туслагчийн бүрэлдэхүүн хэсэг байна. Юуны өмнө, тэр нь олон талын ажиллагаатай, ноён нуруутай, хамтран ажиллах бололцоог бүрдүүлж өгнө. Агуулга нь юуны өмнө, бүтээгдэхүүний “Амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээ(AMУ)-гээр түүнийг булшлах хүртлэх асуудалд тулгуурлана.

Үйлдвэрлэлийн, эсвэл худалдааны эцсийн хэрэглэгч байгаа тохиолдолд, шаардлагын цар хүрээ нь нийлүүлэгчтэй харьцах чадвартай, эцсийн хэрэглэгч, буюу эцсийн томоохон хэрэглэгчийн техникийн экспертизийн шаардлагыг тусгахын тулд уян хатан байх хэрэгтэй. Үр дүнгийн нэг бол агуулга нь хаягдлыг булшлахдаа бус, харин түүний оронд тухайн хаягдал бүтээгдэхүүнийг авч үзэж, амьдралын мөчлөгийн дагуу дахин боловсруулахаар зохих нийлүүлэгчид өгөх ёстой.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын талаар хэрэглэгчийн саналыг боловсруулахтай холбогдуулан авч үзэж оруулах зүйл нь:

MNS ISO/TR 14025 : 2001

- хөндлөн(гурав даь тал)-гийн этгээдийн баталгаажуулалт;
- бүтээгдэхүүний ангилалтай холбогдсон нийтлэг маягт;
- амьдралын бүрэн мөчлөгийн асуудал;
- байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөр, түүний агуулгыг боловсруулах талаар сонирхогч-талуудад дамжуулалт;
- АМНҮ(ISO 14042)-ний, эсхүл амьдралын мөчлөгийн нөлөөллийн талаархи өгөгдлийн задлан шинжлэх хувилбар арга зүйн дагуу ангилалын нөлөөлөлд чиглүүлсэн байх.

7.3 Байгаль орчны мэдэгдлийн боловсруулалт, маяг хэлбэр

7.3.1 Ерөнхий зүйл

Байгаль орчны III загварын мэдэгдлийн талаар Олон улсын стандарт боловсруулах шийдэлд үргэлж хэрэглэх тохиромжтой маягт, бичлэгийг хийх бөгөөд стандартчилсан байж болно. Энэ ялдамд, байгаль орчны III дахь загварын мэдэгдлийг маш бага зай талбайтай байхаар хийнэ. Харин маягт, бичлэг нь янз бүрийн боломжуудыг бодолцсон өргөн утгатай байвал зохино.

7.3.2 Байгаль орчны III загварын мэдэгдлийн боловсруулалт, маягтын хувилбарын боломжтой байдал

Олон улсын стандартыг үргэлжлүүлэн цаашид хэрэглэх асуудал бол тухайлсан мэдэгдлийн маяг, эсвэл уян хатан байхаар дор дурдсан зүйлийг онцлон үзэж болно. Энд оруулах хувилбарын түлхүүр нь:

- дэлхий дахинд, байгаль орчны III загварын мэдэгдлийн маяг хэлбэр, агуулгыг бүх бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирохоор тодорхойлж олон талын хамтын ажиллагаанд хүлээн зөвшөөрсөн байх;
- бүс нутгийн эсвэл үндэсний хэмжээний мөрдөх журам нь худалдаалсан бүтээгдэхүүнд хэрэглэгдэх, харин нэгээс нөгөөд хувирч, соёлын янз бүрийн байдлыг хүлээн зөвшөөрөх ба байгаль орчны талаархи хэрэглээний ялгаа чухал эсэхийг хамаарахад хандуулбал зохино.
- мэдээллийн загварын үндэслэл нь бүх бүтээгдэхүүнийг бүхэлдээ, онцлог бүтээгдэхүүний ангилалын ач холбогдлыг боловсруулахад бусад мэдээллийг нэмж тодорхойлон тогтоосноор тооцогдох болно.
- бүх бүтээгдэхүүний ангилалын дагуу байгаль орчны мэдэгдлийн III загварыг бүрдүүлсэн ялгаа нь мэдэгдлийн төрөлд үндэслэх бөгөөд энэ ангилалаар ач холбогдлыг ихэнхидээ урьдал болгон авч үзэж, шийдвэрлэнэ.
- байгаль орчны III загварын шаардлагын ялгаатай төрөл нь хэрэглэгчийн хувьд янз бүр(ө.х үйлдвэрлэлийн худалдаачид, хэрэглэгчдийн эсрэг) буюу
- бусад

7.3.3 Мэдэгдлийг бүрдүүлэхэд анхаарч үзэх үр дүн

Ер нь , мэдэгдлийг бүрдүүлэхэд анхаарч үр дүнд оруулах зүйл нь:

- ямар зүйл оруулахад итгэлгүй байдал үүдэх вэ ?
- байгаль орчны авч үзэх асуудлын талаархи мэдээллийн эсрэг зохих баримт нь тухайлбал, тухайн бүтээгдэхүүний ямар ч согоггүй буюу гэмтэл нь “тэг” (ө.х агаарт цацагдах хортой бодис бохирдолгүй) бол хэрхэн яаж удирдан зохицуулах вэ ?
- төөрөгдөл буюу будлианд орохгүй замаар АМУ-нээс мэдээллийн янз бүрийн хэлбэрээр хэрхэн яаж цогцолбор болгож авах вэ ?
- амьдралын мөчлөгийн холбогдолтой техникийн асуудал, тухайлбал тогтолцооны зааг болон тархалтын аргыг сонгох, газар зүйн байрлал, тун хэмжээ/хариулт төгсгөлийн хугацааны турш(ө.х амьдралын мөчлөгийн нөлөөлөх байдлын үнэлгээний үед) хэрхэн яаж удирдах вэ ?
- бүтээгдэхүүний болон байрлалын онцлог(эсвэл өгөгдлийн хэсэг үү), эсвэл эдгээрийн дундажийн аль нэг өгөгдөл нь үү ?
- байгаль орчны мэдэгдлийн III загварыг хэтрүүлэггүй, эсвэл үнэ цэнийг нь бууруулалгүйгээр, түүний холбогдох мэдээллийн маяг хэлбэрийн тоо хэмжээ, дэс дарааллын талаар эцсийн хэрэглэгчийг янз бүрээр хэрхэн яаж хангах вэ ?
- графикийн, тооны тусламжтай, эсвэл хоёуланг нь хамтад нь өгөгдлийн сүлжээнд оруулах уу ?
- тоон биш мэдээлэл(ө.х байгаль орчны тогтолцоог)-ийг хэрхэн яаж холбох, ер нь болох уу ?
- үр дүнгийн холбогдолтой, эсвэл гаралтууд, тэдгээрийн уялдаа хамаарлын тодорхойлолтыг хэрхэн яаж тайлбарлах вэ ?
- тайлагнах ёстой амьдралын мөчлөгтэй холбоо бүхий бүх өгөгдөл нь буй эсэх, эсвэл сонгож болох ба бусад хассаныг онцлон үзвэл мэдээллийн төрөлд багтаж байна уу ?
- цаг хугацааны хувьд хэрэгжүүлэлт нь ялангуяа сав боодлын талаархи мэдэгдэл ердийн хэлбэрээр их эрэлт хүсэлттэйгээр, ашиглах хугацаа үргэлжлэх үү ?
- байгаль орчны мэдэгдлийн III загварыг яаж бүрдүүлж болох, бусад чухал мэдээллээс хазайхгүй байдлаар ашиглалтын заавар, аюулгүй/ эрүүл ахуйн талаар анхааруулж, нитридтэй холбогдох мэдээлэл(энэ тохиолдолд хүнсний бүтээгдэхүүнд хамаарах)-ийн талаар ихэнхи улс орнууд хуулиараа ямар нэгэн зүйлийг шаардах уу ?

MNS ISO/TR 14025 : 2001

- бенчмаркинг, эсвэл суурь баталгаажуулалтын талаар байгаль орчны мэдэгдлийн III загвар нь зохих мэдээллийг багтааж чадах уу ?
- байгаль орчны мэдэгдлийн III загвар нь АМҮ-ний судлагааны заагийг тодорхойлж чадах эсэх ?
- сав боодлын, талаархи байгаль орчны мэдэгдлийн III загвар, мэдэгдэл нь хэрэглэгчдэд зориулаагүй бол худалдааны цэгийн, эсвэл түүгээр зарим бусад ач холбогдлыг хангаж болох эсэх ?
- оролтын урсгалд сонирхогч талуудын оролцоо хэрэгтэй эсэх ?
- байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулж сонгон авсан бүх мэдээлэл нь нийтдээ будлиангүй байхаас гадна тараахад (ө.х их хэмжээний хуримтлуулсан мэдээллийн бичвэрийг шилжүүлэх, дахин багцлах нь хүндрэлтэй байж болох) практикт өндөр өртөг зардал шаардах эсэх ?
- байгаль орчны III загварын боловсруулалт, хэрэглэгчдийн хэрэгцээ бүрдүүлэлтийн баланс, мэдээллийн дүн, соёлын янз бүрийн хүрээнд уг мэдээллийг нь хэрхэн яаж тохируулж ашиглах бэ ?
- нэг хэлнээс нөгөө хэл дээр хөрвүүлэх ажлыг хэрхэн яаж тохируулж хангах вэ ?
- ашигласан арга зүйн онцлогийн хязгаарлалтыг боломжийн худалдан авагч, худалдагчид хэрхэн яаж мэдэх, мэдэж болох уу ?
- аргазүйн тухай болон цаашдын өгөгдлийн талаар нэмэлт мэдээлэл авахаар бол мэдэгдлийн хувилбарыг яаж мэдээлэх вэ ?
- бусад.

7.4 Байгаль орчны мэдэгдлийн III загварыг бусад эко-тэмдэгтэй хамтад нь хэрэглэх

ISO 14001(БОМТ) стандартын тохирлын болон байгаль орчны мэдэгдлийн эко-тэмдэг хэрэглэх I ба II загварыг III загварт шингээж хамтад нь хэрэглэхгүй байвал зохино. Энэ нь түүний бүрэлдэхүүнийг хангахын тулд байгаль орчны эко-тэмдэг хэрэглэх тухай олон улсын бусад стандартууд(өөрөөр хэлбэл, ISO 14020, ISO 14021, ISO 14024)-тай хамт хэрэглэнэ. Гэсэн хэдий ч, адилхан бүтээгдэхүүн, сав боодол, тайлан, интернетийн байрлал гэх мэт асуудлаар байгаль орчны мэдэгдлийн III загвараас салангид ашиглах эко-тэмдгийн бусдыг хасаж үл болно. Ийм учраас практик ажиллагаанд арга зүйн зааварчлага нь чухал бөгөөд адилхан бүтээгдэхүүн буюу сав боодлын талаархи байгаль орчны мэдэгдлийн хоёр ба түүнээс дээш хэлбэр маягийн оролцоогоор төөрөгдөх, эсвэл эцсийн хэрэглэгч нь мухардалд орох зэрэг таагүй боломжуудаас зайлсхийх, эсвэл хамгийн бага боломж олгохоор боловсруулах хэрэгтэй. Энэ нь дүрмийн гол зүйл боловч, байгаль орчны мэдэгдлийн III загвар, бусад аливаа мэдэгдлийн хооронд түүнийг дагалдуулсан ч, тодорхой ялгаа байх ёстой. Энэ нь байгаль орчны талаархи мэдэгдлийн бүх маяг хэлбэр, харилцаанд хамаарна.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын мэдэгдлийг хэрхэн яаж оруулах, эсвэл байгаль орчны менежментийн тогтолцооны тохирол, мөн үнэлгээ хийлгээгүй, тухай

мэдэгдлийг дагалдуулах уу. Олон улсын стандарт, заавар болон бусад материалын хангалт, шаардлага, зөвлөмж нь хэрэгтэй эсэхийг шийдвэрлэж байх болно. Тэдгээрт ISO 14021, ОУСБ/ОУЦТК-ын 2 тоот аргазүйн удирдамж, ISO 14001-ын баталгаажуулалтаар хэвлүүлсэн эмхэтгэл орно.

7.5 Туршлага, судлагаа

Зах зээлийн нөхцөлд эцсийн хэрэглэгч практик дээр хэрхэн дүн шинжилгээ хийж, янз бүрийн хандлагыг тайлбарлан тодорхойлох шаардлагатай. Энд байгаль орчны мэдэгдлийн III загварын бүтэц, хэлбэр маягийг эцсийн хэрэглэгчээс ойлгох, хүлээн авахтай холбогдуулан нарийвчилсан хэмжээ, өгөгдлийг хэрхэн яаж тодорхойлж оруулахыг заана. Эцэст нь, байгаль орчны III загварыг боловсруулагч, сонирхогч талуудаас мэдэгдэл, түүний агуулга нь нэг ангилалаас, эсвэл газар зүйн бүсчлэлийн нэг байрлалаас нөгөөд шилжиж дүн шинжилгээ хийх явцад янз янзаар өөрчлөгдөхөд уян хатан, будлихгүйн тулд олон талын эсрэг асуудлыг бодолцож үнэлэх хэрэгтэй.

8 Байгаль орчны мэдэгдлийн III загвар, хөтөлбөрийг тогтоох журам

8.1 Ерөнхий зүйл

Байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулахад хамгийн багаар бодоход, гурван үе шаттай байна. Үүнд: - мэдэгдлийн бэлтгэл, нотолж батлахад ашиглах арга болон баталгаажуулалт нь зөвхөн байсан аргууд, тэгэхдээ засвар оруулсан мэдээлэл байна.

Байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулах, ашиглах үед холбогдох журамд оруулах асуудал нь:

- a) байгаль орчны талаархи мэдэгдлийн III загварыг хэн боловсруулах,
- b) байгаль орчны мэдэгдлийн III загварын баталгаажуулалтад хэн хэнийг татан оролцуулах,
- c) тухайн ажлыг боловсруулахын тулд шалгуур, эсвэл чанарын зарим мэдэгдлийг боловсруулагчийн асуудал уу гэдгийг цуглуулах,
- d) нэг орны хэмжээнд нэг ажлыг бүгдийг нь хийж гүйцэтгэсэн бол тэдгээрийг нөгөө оронд хэрхэн яаж хүлээн зөвшөөрөх, болон
- e) дэлхийн орчин тойронд болж буй үйл явцыг нэг хэсэг хувааж болох ажил нь хэрхэн яаж өрнөн хөгжиж буй талаархи чадварыг мэдээлэгчид мэдээлэх.

Байгаль орчны мэдэгдлийн III загварыг үр дүнтэй хөгжүүлэх шаардлагатай журам нь нэг сектороос нөгөөд, нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрт үлэмж хэмжээгээр өөрчлөгдөж болно. ISO 14024-ыг байгаль орчны мэдэгдлийн III загварыг хөндлөнгийн баталгаажуулалтад нийцүүлэхэд хэрэглэгдэх ерөнхий аргазүйн журмаар хангахад хэрэглэнэ.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрийг хувийн хэвшлийн болон олон нийтийн байгууллагуудаас үйлдэж болно:

MNS ISO/TR 14025 : 2001

- байгаль орчны мэдэгдлийн III загварын тухай ерөнхий мэдээлэлтэй холбогдсон баримт бичгийн дэмжлэг туслалцааг үзүүлж хангах,
- байгаль орчны мэдэгдлийн III загварын холбогдолтой нийтлэг аргагүйг хөгжүүлэх,
- байгаль орчны мэдэгдлийн III загварын холбогдолтой хөтөлбөрийн талаар болон онцлог бүтээгдэхүүний мэдээллийн наад захын шаардлагын талаар баримт бичгийн дэмжлэг туслалцаа үзүүлж хангах,
- хөндлөнгийн этгээдэд зориулсан энэхүү техникийн тайлангийн тайлбарын тухай баримт бичгийн дэмжлэг туслалцааг үзүүлж хангах.
- тэдгээр хөндлөнгийн этгээдэд зориулсан үзлэг шүүмж явуулахтай холбогдуулан эрх мэдлийн талаар шаардлагатай баримт бичгээр хангаж дэмжих, хөгжүүлэх.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрийн шаардлага, тодорхойлолт ба сонирхогч талуудтай илэн далангүй зөвлөлдөх ажлын нэг хэсэг нь шалгаж нотлох тохирох хэлбэр нь байгууллагын үзлэг шалгалт байна.

В хавсралтад байгаль орчны мэдэгдлийн III загварын янз бүрийн хэлбэр маягтай жишээг үзүүлсэн.

8.2 Хөтөлбөрийн хамгийн наад захын шаардлага

Байгаль орчны мэдэгдлийн III загварт хамаарах хамгийн наад захын шаардлагыг хөтөлбөрийн бүх хэсэгт тодорхойлон оруулж тусгасан байвал зохино. Тэдгээр нь ISO 14020 ба АМУ-ний ерөнхий аргагүйн дагуу амьдралын мөчлөгийн үнэлгээнд зориулсан Олон улсын холбогдох стандартад заасан зарчмуудтай ижил төсөөтэй байна.

8.3 Бүтээгдэхүүний ангилалын сонголт

Бүтээгдэхүүний ангилалыг ямар нэг сонирхогч талуудаас санал оруулж болно. Санал болгож буй бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүний ангилалын хөтөлбөрт нь зориулж, уг саналынх дагуу авч хэлэлцэх болон үнэлэмжийн түлхүүр баримт бичгийг нийтэд нь баримтжуулсан байна. Түүнд бүтээгдэхүүний үүрэг-функцийн үзүүлэлт, функционал нэгжийн тодорхойлолтын тогтвортой байдал, байгаль орчны холбогдолтой бүтээгдэхүүний чадамж, байгаль орчны III загварт хамаарах бүтээгдэхүүнийг сонирхон оролцогчид, хэрэглэгчдийн саналын үнэлгээг оруулна.

8.4 Холбогдох шаардлага

Суурь асуудал нь: Техникийн болоод ухаалаг үйл ажиллагаа хоёулангаар, ямар нэгэн стандартын шаардлага нь эрх өгч чадах уу? Санал нь тухайлбал, үндэсний хэмжээнд мөрдөж, ашиглаж буй хуулиуд ба өөрсдийн ажлаа хөнгөн итгүүлэх боломжоос тус тус хамаарна. Тэдгээрийн төгсгөл нь хоёулаа байгаль орчны мэдэгдлийн III загварын ашиглах (тусгай бүрэн эрхт комиссар нь) эрх олгоход чиглэнэ. Аливаа комиссар нь түүний ашигтай байдлыг нэмэгдүүлэх замаар хөнгөн итгүүлэх, хүсэх ба хуулийн шаардлагыг хангах ёстой.

8.5 Баталгаажуулалт

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрийн холбогдолтой зураг дээрх зохион байгуулалт нь баталж нотлох хэлбэр маягаар уг хөтөлбөрт тавих шаардлагыг тодорхойлно.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын баталгаажуулалтыг хуулийн дагуу саналаар үлдэж, хэн түүнийг хуулиар болон шаардлагатай хөнгөлөлт үзүүлж, итгүүлэх байдлаар засаглан шийдвэрлэж байгаагаар зохицуулж байна.

8.6 Итгэмжлэл

Итгэмжлэл хэрэгтэй юу, үгүй юу гэвэл худалдааг болон бүтээгдэхүүний үйлдвэрлэн гаргалтыг тохируулахтай холбогдуулж, практик ажиллагаанд өөрт нь шаардлагатай болно. Үндэстэн бүрийн хөгжил нь тодорхой байр суурь эзлэх магадлалтай бөгөөд энэ чиглэлийн үйл ажиллагаанд цаашид хамгийн ач тустайгаар тодорхойлогдох болно.

8.7. Олон талын харилцан хүлээн зөвшөөрөлт

Олон улсын хэмжээний мэдэгдлийг итгэлтэй хийхийн тулд олон талын хүлээн зөвшөөрөлт нь хэрэгцээтэй гарцад чиглэсэн байна. Энэ гарцыг байгууллагын үйл ажиллагаатай нягт холбож, нэг нь нөгөөгийнхөө ажлыг хүлээн зөвшөөрөх хүсэлт тавина. Хувийн байгууллагууд хүлээн зөвшөөрөх асуудлыг боловсруулбал нэг улс орон, нөгөө улс оронтой уг ажлыг хөнгөн итгүүлэх боломжийг нэмэгдүүлж өгнө.

Үндэсний хуулийн болон олон улсын гэрээ хэлэлцээрийн шаардлагыг мөн мөрдөх шаардлагатай.

8.8 Технологи дамжуулалт

Байгаль орчны мэдэгдлийн III загварын шаардлагатай ажлыг нийцүүлэн хөгжүүлэх боломж нь дэлхийн хэмжээнд хүлээж авах ирээдүйтэй байх хэрэгтэй. АМҮ-ний өгөгдөл(цаашид ISO 14048 стандарт)-ийн маяг хэлбэрийг уялдуулан зохицуулж уг ажлыг хөнгөлөх болно.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын болон нууц биш баримт бичиг, өгөгдөл нь олон нийтэд боломжийн хэмжээгээр нээлттэй байна.

8.9. Тогтмол үзлэг шалгалт

Тогтмол үзлэг шалгалт нь байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрийн дагуу эрх бүхий байгууллагаас тогтоох журамд, нээлттэй зөвлөлдөх явцад оролцогч, сонирхогч талуудтай хамтран боловсруулж тодорхойлохоор бол зохих мэдээллийг урьдчилан тогтоосон хугацаанд сайжруулах ойлголцолыг бий болгоход чиглэнэ.

А. Хавсралт(зөвлөмжийн)

Арга зүйн дүн шинжилгээ, тэдгээрийг байгаль орчны мэдэгдэлд хэрэглэх нь

А.1 Амьдралын мөчлөгийн үнэлгээ, АМҮ (ISO 14040 цувралын стандарт)

А.1.1 Тодорхойлон бичих

Бүтээгдэхүүнтэй холбогдож, байгаль орчны асуудал, үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх зориулалтын АМҮ-ний арга нь:

- бүтээгдэхүүний тогтолцооны оролт, гаралтын урсгалтай холбогдол бүхий цэс зохиох,
- Тэдгээр оролт, гаралттай холбоо бүхий байгаль орчны сөрөг нөлөөллийн боломжтой байдлыг үнэлэх,
- судлагааны зорилгод холбогдолтой нөлөөлөх байдлын үнэлгээ болон задлан шинжлэх цэсийн үр дүнгийн утгыг нь тайлбарлах.

Байгаль орчны асуудал болон үзүүлэх сөрөг нөлөөллийн боломжит байдал нь түүхий эд, материалыг худалдан авахаас эхлэн үйлдвэрлэлд ашиглах, хаягдал хүртэл бүтээгдэхүүний амьдралын мөчлөг(өөрөөр хэлбэл булшлах)ийг АМҮ-ний судалгаанууд хийнэ. Байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий ангилалыг авч үзэхдээ ашиглалтын нөөц, хүний эрүүл мэнд болон экологийн үр дагаварыг оруулна.

АМҮ нь дөрвөн үелэл(фаза)-ээс бүрдэнэ: зорилгын тодорхойлолт, амьдралын мөчлөгийг задлан шинжлэх цэс, амьдралын мөчлөгийн нөлөөлөх байдлыг үнэлэх, үр дүнгийн талаархи амьдралын мөчлөгийн утгын тайлбар(ISO 14040 : 1997, 1 дүгээр зураг үзнэ үү.)

АМҮ -ний боловсруулалт нь эхний үедээ ахиц муутай байсан. АМҮ-ний аргын зарим үелэл болох нөлөөлөх байдлын үнэлгээ нь хөгжлийнхээ эхний шатанд байна. АМҮ-ний талаар хуримтлуулсан туршлага, хийсэн нэлээд ажил нь цаашдын практик ажиллагааг боловсронгуй болгож, амжилтад хүрэх юм. Юуны өмнө, АМҮ-ний үр дүнг утгын хувьд тайлбарлахад их чухал болох бөгөөд тохиромжтой арга болно.

АМҮ-ний судалгааны нарийвчилсан түвшин, хамрах хүрээ, тогтолцооны зааг нь уг судалгааны санал болгосон ашиглалт, сэдвээс хамаарна. АМҮ-ний судалгааны өргөн цар хүрээ, гүнзгий байдал нь ялангуяа АМҮ-ний практик ажлын зорилгоос үлэмж хамааралтай нь ялгарч харагдана. Гэсэн хэдий ч, бүх тохиолдолд ISO 14040 стандартаар тогтоосон бүтэц, зарчмыг баримтлах нь зүйтэй.

АМҮ нь байгаль орчны менежментийн тогтолцооны хэд хэдэн аргын нэг (ө.х эрсдэлийн үнэлгээ, байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ, байгаль орчны аудит явуулах болон байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ) бөгөөд бүх тохиолдолд ашиглахад бараг тохирохгүй арга нь байна. АМҮ нь бүтээгдэхүүнтэй холбогдон нийгэм, эдийн засгийн асуудалд нь үлгэрчилсэн байдлаар хандуулаагүй юм.

Яагаад гэвэл бүх арга хязгаарлагдмал бөгөөд тэр нь АМҮ-ний бүтэц бичлэгт түүнээс ойлгоц авахад чухал юм. Энэ хязгаарлалтад дараахь зүйлийг оруулна:

- АМҮ-г сонгох ба хариуцлага хүлээхээр хийсэн бодит зүйл (ө.х. тогтолцооны зааг тогтоох, өгөгдлийн эх үүсвэрийн сонголт, нөлөөллийн ангилал) зэрэг сэдэв байж болно.
- Задлан шинжлэх цэст зориулан ашигласан загварыг, эсвэл байгаль орчны нөлөөлөх байдалд хүрэх боломжийн хувьд, тэдгээрийн үүрэг хариуцлага хүлээх байдлаараа хязгаарлагдмал ба хэрэглээ нь, эсвэл бүх нөлөөлөл нь бодитой биш байж болно.
- АМҮ-ний судалгааны үр дүнг даяарчлалын болон бүс нутгийн, нутаг дэвсгэрийн хэрэглээнд тохиромж муутай байж болох бөгөөд ө. х. орон нутгийн нөхцөлд байдал нь даян дэлхий, бүс нутгийн нөхцөл байдалд их боломжгүй байгаа талаар танилцуулахад чиглэнэ.

АМҮ-ний судалгаа зөв эсэх нь холбогдох өгөгдлийн хүртээл, эсвэл боломжийн хувьд хязгаарлагдмал, эсвэл өгөгдлийн чанараар ө. х. өгөгдлийн төрөл, зай завсар, цогцолбор үзүүлэлт, дундаж хэмжээ, байрлалын онцлог байж болно.

Өгөгдлийн задлан шинжлэх цэст хэмжүүрийн шинж төлөв, орон зайн дутагдал нь нөлөөллийн үр дүнд тодорхой бус байдлыг түүний үнэлгээнд зориулан ашиглана.

А. 1.2 Амьдралын мөчлөгийн задлан шинжлэх цэс , АМҮ(ISO 14041)

А.1.2.1 Тодорхойлон бичих

Байгаль орчны мэдэгдлийн III загварын боловсруулалт нь АМНБ-д АМҮ-ний анхны хоёр үелэл(фаза)-ээс бүрддэг; зорилго, хамрах хүрээний тодорхойлолт ба задлан шинжлэх цэс болон дөрөв дэх үелэл нь; АМ-ийн утгын тайлбарлалт (ISO14043).

Зорилго, хамрах хүрээний тодорхойлолтын үелэл нь их чухал, АМҮ-нь яагаад хэрэгцээтэй нийцүүлэн гаргах(ашиглалтын дүнг оруулна гэж ойлгох) ба тодорхойлон бичих тогтолцоо, өгөгдлийн ангилалыг тус тус судалвал зохино. Зориулалт, хамрах хүрээ ба нөлөөллийн судалгааг ашиглахад анхаарч, түүний гүнзгийрүүлэлт, өгөгдлийн хэрэгцээт чанар, үргэлжлэх хугацаа, газар зүйн хэр хэмжээнд чиглэнэ.

АМНБ-ын үелэлийн утгын тайлбар(ISO 1401 1998-д заасан 7-р зүйл үзнэ үү.)-т өгөгдлүүд нь нэмэлт мэдээллийн цуглуулга хамрах хүрээ, эсвэл хоёулангийн зорилгод тохиромжтой хэлбэрээр үнэлэгдэнэ. Мөн утгын тайлбарлах үелэлийг тайланд бичих зорилгоор өгөгдлийг ойлгон, үлгэрлэн сайжруулахад чиглэнэ. АМНБ нь оролт, гаралтын өгөгдлийг цуглуулах, задлан шинжлэх болон эдгээр өгөгдлийг байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээгүй, дүгнэлтийг бэлэн үндэслэл болгож чадахгүй.

А.1.2.2 Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан гаралт (бүтээгдэхүүн)

АМНБ-ын үр дүнгүүд нь байгаль орчны нөөц баялаг, материалын болон эрчим хүчний нэгж хэрэглэгчтэй холбогдох нэр томъёонд оролтыг үлгэрчилсэн байдлаар илэрхийлнэ. Гаралт(бүтээгдэхүүн)-ыг илэрхийлэх зүйл нь, жишээлбэл: агаар, ус болон хөрсний бохирдлыг хэлж болно. Байгаль орчны мэдэгдлийн III загварт АМНБ-

аас оролт, гаралтын талаар тайлан гаргах сонголт нь хааяа тэдгээрийн талаар, түүнчлэн АМНБ-ын үр дүнгийн утгын тайлбарын бараг бүх холбогдол тогтооход үндэслэгдэнэ. Функционал нэгжид холбогдох оролт, гаралтын бүх урсгалд тооцоо хийж байна.

А.1.2.3 Хязгаарлалт

Байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулахдаа АМНБ-ыг ашиглахаас нь харьцуулагдах зарим онцлог хязгаарлалтад дараахь зүйл ангийг тодорхойлон бичих нь зүйтэй. Үүнд:

- байгаль орчны холбогдол, эсвэл бодит нөлөөллийн шинж төлөвгүйгээр зөвхөн АМНБ-ын оролт, гаралтын холбоос хэлбэрээр байна. Ийм учраас АМНБ-ын янз бүрийн оролт, гаралтын онц чухал байдлаар нь хэтэрхий өндөр, эсвэл хэтэрхий бууруулж үнэлэх тал бий. Ингэхдээ түүнийг байгаль орчны мэдэгдлийн III загварыг үндэслэн, гол нь эцсийн хэрэглэгчээс зохицуулан явуулна. Жишээлбэл, Тухайн үйлдвэрлэгч нь хортой зүйлийг бага хэмжээнд байлгах ойлголтоос хол хөндий бол, химийн хортой бодисоос үүдэн гарах хамгийн доод хэмжээний оронд хамгийн их бохирдол үүсгэхээр байхыг үгүйсгэхгүй.
- материалыг дахин боловсруулж ашиглах явдлыг бүтээгдэхүүн бүрт бодолцох ёстой бөгөөд АМНБ-ын үр дүнг янз бүрийн тогтолцоогоор нь журмын зориулалтад нь үндэслэнэ.
- эдгээр зориулалт нь байгаль орчны мэдэгдлийн III загварын сүлжээнд төвөгтэй байж болох юм. Энэ нь ялангуяа эцсийн хэрэглэгчид төвөг бэрхшээлтэй, гэхдээ үйлдвэрлэлийн их дур булаах, эсвэл худалдааны хэрэглэгч нь шаардагдах зүйл биш.
- АМНБ-ын үр дүнг нэгж үйлдлийн ажиллагаагаар бохирдолыг нийлүүлэн нэгтгэх, мөн янз бүрийн цаг хугацаа, байрлалд зохих аргаар түүнийг хамтад нь янз бүрийн хэлбэрээр хуримтлуулан авч үзнэ. Тийм хуримтлалыг тээвэрлэхдээ гэж үрэгдүүлж болох талтай. Жишээлбэл: Органик дэгдэмхий бодисыг массын үндэслэлээр нь хуримтлуулж болох ба органик дэгдэмхий бодисын бүрэлдэхүүнийг тус бүрд нь биш, тэдгээрийн нийлбэр дүнг нь тайланд бичвэл зохино.
- АМНБ –ын үр дүн нь судалгааны зорилго, хамрах хүрээний дагуу уялдаа холбоотой байвал зохино. Энэ уялдаа холбоонд өгөгдлийн чанарыг үнэлэх, үр дүнгийн тодорхой бус байдлыг ойлгохын тулд задлан шинжлэх мэдрэмжээр, оролт гаралтын ач холбогдол, арга зүйн сонголтыг тус тус оруулна. Задлан шинжлэх цэсийн уялдаа холбоо нь мөн судалгааны зорилго, хамрах хүрээнд холбогдолтой дараахь зүйлийг авч үзнэ. Үүнд:
 - a) тохиромжтой функционал нэгж , тогтолцооны үүргийг тодорхойлох уу ?
 - .b) тохиромжтой тогтолцооны заагийг тодорхойлох уу ?
 - c) дүн шинжилгээний мэдрэмж, өгөгдлийн чанарын үнэлгээгээр хязгаарлалтыг тодорхойлох уу ?

Үр дүнг болгоомжлохтой холбогдуулан тайлбарлах, яагаад гэвэл байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлд нь биш, тэдгээр өгөгдлийн оролт, гаралт руу чиглүүлэх хэрэгтэй. Тухайлбал, АМНБ-ын судалгааны дагуу харьцуулах үндэслэл нь байж болохгүй.

Нэмэлт болгоход, АМНБ-ын үр дүнд өгөгдлийн янз бүрийн байдал, оролтын тодорхой бус байдлын нийлбэр, үр дүнгээр шууд танилцуулах хэрэгтэй. Тодорхой бус байдлын задлан шинжилгээг АМНБ-д хэрэглэх техникийн арга, түүний боловсронгуй бус байдалд хандуулна. Гэхдээ тэр нь АМНБ-ын дүнд тодорхой бус байдлыг тодорхойлох, дүгнэлт хийх ба/буюу боломжоороо тархалтын дүнгээр зэрэглэл ашиглаж, тодорхой бус байдлыг тогтоож тодорхойлоход тусална.

Тийм задлан шинжилгээ нь хэзээ ч гэсэн, хэрэгжих ба АМНБ-ын дүгнэлтийг дэмжиж, сайн тайлбарлахад чухал үүрэгтэй.

Өгөгдлийн чанарын үнэлгээ, задлан шинжилгээний мэдрэмж, дүгнэлт болон АМНБ-ын үр дүнтэй холбогдох ямар нэгэн зөвлөмжийг баримтжуулсан байна. Дүгнэлт, зөвлөмж нь дээр дурдсан шийдвэртэй холбогдсон үнэлэмжээс бүрдэнэ.

АМНБ-ын судалгааны нөлөөллийн үнэлгээний үелэлд холбогдох АМНБ-ын олон тооны хязгаарлалт байна.

A.1.2.4 Судалгааны хэрэгцээ

Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан АМНБ-ын ашиглалтыг сайшаан дэмжихийн тулд эцсийн хэрэглэгчтэй холбогдол бүхий нарийвчилж чадах, уг мэдэгдлийн загварт хэрхэн яаж үндэслэхийг ойлгоход судалгаа хэрэгцээтэй. Нэмэлт болгон хэлэхэд, байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрт суурилсан АМНБ нь түүний талаархи өгөгдлийг цуглуулах, чанарыг сайжруулах, тохиромжтой байдал, өртөг зардал бууруулах зэрэг ажилд ерөнхий судалгаа ашигтай.

A.1.3 Амьдралын мөчлөгийн нөлөөлөх байдлын үнэлгээ-АМНБҮ(ISO 14042)

A.1.3.1 Тодорхойлон бичих

АМНБҮ-ний онцлог түлхүүр асуудалд дараахийг жагсааж бичнэ:

- АМНБҮ-ний үелэл нь АМУ-ний үелэлийн бусадтай холбоход нэг ба хэд хэдэн эх үүсвэрийн төгсгөл, байгаль орчны талаархи хэтийн тогтолцооны өргөн цар хүрээг хангавал зохино.
- АМНБ-ын үр дүн нь ангилалын нөлөөлөлд АМНБҮ-нд зориулагдана. Ангилалын нөлөөлөх байдал бүрт зориулсан ангилалын заагч(индикатор)-ийг сонгох бөгөөд түүний үр дүн нь дор тооцсон үр дүнгийн заагчид чиглэнэ. Заагчийн үр дүнгийн цуглуулалт нь тухайн бүтээгдэхүүний тогтолцоонд хамааралтай байгаль орчны талаархи оролт, гаралтын төгсгөлийг нэгтгэж, АМНБҮ-ний нарийн мэргэжлийн мэдээллээр хангахад цаашид чиглэгдэнэ.
- байгаль орчны гүйцэтгэлийн, нөлөөлөх байдлын болон эрсдэлийн үнэлгээнээс хамаарч, техникийн хувьд АМНБҮ нь ялгаатай бөгөөд тэр нь холбогдол бүхий

MNS ISO/TR 14025 : 2001

функционал нэгжид үндэслэнэ. АМНБҮ нь тэдгээр бусад аргын талаар ашиглах мэдээллийг хуримтлуулна.

АМНБҮ-ний үелэлийн ерөнхий бүтцээр заагчийн үр дүнд АМНБ-ын дүнг хувиргахаар мандатын нэлээд хэдэн заагчийг зохиож бичнэ. Нэмэлт болгоход, стандартчилахаар эдгээр хувилбарын элементийг бүлэглэх, эсвэл заагчийн үр дүн, өгөгдлийн чанарыг задлан шинжлэх аргыг чигнэх(жинлэх) явдал юм. АМНБҮ -ний үелэл(фаза) бол АМУ-ний холбогдох бүх судалгааны зөвхөн нэг хэсэг бөгөөд ISO 14042 : 2000 стандартын А. Хавсралтын дурдсан АМУ-ний бусад үелэлтэй зохицуулах ёстой. АМНБҮ-ний үелэлийн элементийг ISO 14042 : 2000 тоот стандартын 1 дүгээр зураг дээр үзүүлсэн. АМНБҮ-ний үелэлийн салбарыг ялгаатай элементэд оруулахад хэд хэдэн шалтгаан хэрэгтэй.

- АМНБҮ-ний элемент бүр нь тайлагнах бололцоотой бөгөөд ойлгомжтойгоор тодорхойлсон байх,
 - АМУ-ний судалгааны зорилго, хамрах хүрээний тодорхойлолт нь АМНБҮ-ний элемент бүрийг тус тусад нь авч үзэх,
 - АМНБҮ-ний чанарын үнэлгээний аргууд, батлах болон бусад шийдвэрийг АМНБҮ-ний элемент бүртэй нийцүүлж чадах,
 - АМНБҮ-ний журам, үүрэг хариуцлага болон элемент бүрийг бусад үйлдэл ажиллагааны талаар тайлан, шүүмжид дамжуулах ажлыг гүйцэтгэх,
 - Дор зааж жагсаасан АМНБҮ-ний мандатын бүрэлдэхүүн хэсэгт орох.
- a) Төлөв байдлын загварчлалын болон ангилалын заагч(индикатор), ангилалын нөлөөлөх байдлын сонголт: Төлөв байдлын загварчлал, төгсгөлийн ангилал ба ангилалын заагчид холбогдсон нөлөөлөх байдлын ангилалын тодорхойлолт, АМНБ-ын үр дүнг нэгтгэсэн нь АМУ-ний судалгаанд чиглэнэ. Жишээлбэл, Цаг уур амьсгалын өөрчлөлт нь хэт улаан туяаны цацраг идэвхит хүч(ISO 14042 : 2000 стандартад заасан 1 дүгээр хүснэгт үз)-ийг ангилалын заагч болгон ашиглаж, ногоон хүлэмж(АМНБ-ын үр дүнг)-ийн хийн ялгаралтыг ойлгож болно.
- b) Ангилалын нөлөөлөх байдалд АМНБ-ын үр дүн(төлөв байдал)-гийн зориулалт,
- c) Заагчийн үр дүн(төлөв байдал)-гийн ангилалын тооцоо

Үр дүнгийн заагч нь бүтээгдэхүүний тогтолцоонд зориулсан АМНБҮ-ний ерөнхий цар хүрээний ойлголтын хамт нөлөөлөх байдалд ялгаатай байна.

АМУ-ний судалгааны зорилго, хамрах хүрээнээс үл хамааран, дор жагсаасан мэдээлэл, бүрэлдэхүүн хэсэг(элемент)-ийн хувилбарыг ашиглаж болно.

- d) **Тооцоолох:** Мэдээллийн стандарт(стандартчилсан)-д холбогдолтой ангилалын заагчийн үр дүнгийн хэмжээг нь тооцоолох,
- e) **Бүлэглэх:** Нөлөөлөх байдлын дугаарлалт, боломжтой зэрэг зиндаа,

- f) **Чигнэх** (буюу жинлэх): Сонгож-үнэлэхээр ашигласан дэс дараалсан хүчин зүйлд тулгуурлаж, ангилалын нөлөөллөөр заагчийн үр дүнг бололцоогоор нь цогцолбор үзүүлэлтэд оруулах ба хувиргах,
- g) **Өгөгдлийн чанарын задлан шинжилгээ**: АМНБҮ-ний цар хүрээг нь цуглуулсан заагчийн үр дүнгийн найдвартай байдлыг хангаж сайтар ойлголцох.

A. 1.3.2 Байгаль орчны мэдэгдлийн III загварын зориулалттай гаралт

АМНБ болон АМНБҮ хоорондын ялгаа түлхүүр нь байгаль орчны III загварын мэдэгдлийн III загварт суурилдаг ба АМНБҮ-г байгаль орчны мэдэгдлийн III загварт суурилж, түүний ангилалын заагчийн тусламжтайгаар төлөв байдлын цар хүрээ, үнэмлэхүй нэр томъёог илэрхийлнэ. Жишээлбэл: Цаг уур амьсгалын өөрчлөлт нь хэт улаан туяаны цацраг идэвхит хүч ийг ангилалын заагч(ISO 14042) болгон ашиглаж, ногоон хүлэмж(АМНБ-ын үр дүнг)-ийн хийн ялгаралтыг ойлгож болно. Функционал нэгжийн үндэслэлээр АМНБ ба АМНБҮ-ний үр дүнгүүдийг илэрхийлнэ.

A. 1.3.3 Хязгаарлалт

Байгаль орчны мэдэгдлийн III загвартай холбогдол бүхий хязгаарлалтын бүх хэлбэрийг ISO 14042 : 2000 стандартын 8 дугаар зүйлд тодорхойлон бичсэн байна. Тэдгээрийн холбогдол бүхий зарим онцлогийг дор дурдаж байна. Үүнд:

- АМНБҮ-ний үр дүн нь ангилалын төгсгөл, аюултай босго, аюулгүй талбай, эсвэл эрсдэлийн нөлөөлөх байдлыг урьдчилан тааж хэлэхгүй. Жишээлбэл: АМНБҮ үлгэрлэвэл, орон зайн, тодорхойлолтын, оргил ачааллын цэгийн түвшин ба тун хэмжээ хариуцах мэдээлэл, бохирдолын хольц буюу найрлага, эсвэл цаг хугацааны ба/буюу орон зай хамарсан үйл ажиллагааг оруулахгүй. Энэ нь байгаль орчны холбогдолтой заагчийн үр дүнгийн цар хүрээ, хэмжээг багасгах болно.
- АМНБҮ нь хаана ч бай, техникийн норм, шинжлэх ухааны аргачлалтай байна. Гэсэн хэдий ч, ангилалын нөлөөлөх байдлын тоо хэмжээ-сонгох,, заагч болон төлөв байдлын загварчлал, бүлэглэж стандартчилах, чигнэх ба бусад журамтай нийцүүлэн сонголт-үнэлгээ ашиглана. Байгаль орчны мэдэгдлийн III загварыг хэрэглэгчид тэдгээр тоо-хэмжээний сонголтыг ойлгож, үнэлэхэд бэрхшээл гардаг тал бий.
- Ангилалын жагсаалтын заагч нь байгаль орчны хэтийн чиглэлээс эн тэнцүү ач холбогдолтой бүх ангилал, мөн дээд хэмжээтэйг нь өөрөөр хэлбэл байгаль орчны нэлээд чухлыг эцсийн хэрэглэгчээс буруу зөрүү ойлгох, эсвэл байгаль орчны бараг л ач холбогдолгүй үл ялих тоог тодорхойлон заах явдал гарч болох юм.

Нэмэлт болгоход, дээр дурдсан онцлог асуудалд, бусад практикаар хязгаарлалт буюу хязгаарлагдмал байдлыг ISO 14042 стандартад бичиж тодорхойлсон нь байгаль орчны мэдэгдлийн III загвар боловсруулалтын турш авч үзнэ.

A. 1.3.4 Судалгааны хэрэгцээ

Дээр тодорхойлон бичсэн хязгаарлалтын холбогдолтой АМНБҮ ангилалын заагчийн үр дүнг янз бүрээр тайлбарлах, эцсийн хэрэглэгчээс байгаль орчны мэдэгдлийн III

MNS ISO/TR 14025 : 2001

загварт суурилсан АМНБҮ-г хэрхэн яаж ойлгох талаар судалгаа шаардлагатай. Энэ судалгааны гаралтын урсгал нь байгаль орчны мэдэгдлийн III загварыг хэрэгжүүлэх үед зохион бүтээлт, гүйцэтгэл ажиллагаа болон хэрэглэгчид нөлөөлж болох юм. АМНБҮ-нд зориулсан өгөгдлийг цуглуулах, төлөв байдлын загварчлалын зардал, ажлын дүнгийн холбогдолтой байгаль орчны мэдэгдлийн III загварт мэдээлэл, нарийвчлалыг зохистой болгох үүднээс судалгаа шаарддаг.

Жишээлбэл, Нөлөөлөх байдалд зориулсан аргын жишээ:

CML арга[8] нь ерөнхийдээ АМНБҮ(ISO 14042-д заасан төлөв байдлын загварчлалын үе шатны зориулалт)-ний ангилалт, төлөв байдлын дараахь үе шатыг нэг алхамд оруулах бөгөөд үнэлгээг ч мөн адилхан авч үзнэ.

Байгаль орчны тэргүүлэх чиглэлийг мэдэж авсаны дагуу байгаль орчны талаархи өвөрмөц онцлогтой гаралтыг сонгож, илүү чухал болохыг янз бүрийн гаралтаас онцлон үнэлэхэд тулгуурлах бөгөөд ангилалын хүчин зүйлээр нь чигнэнэ. Инвентар(цэс)-ийн дүн нь тэдгээр хүчин зүйлүүдийг тэнцүү утгатайгаар хандуулан байгаль орчны ашиг тусыг сонголт-үнэлгээнд үндэслэж, ойролцоо тархалтад хувиргана.

Үр дүнгүүдийг нийтэд хүснэгтийн хэлбэрт оруулна. Тэдгээр ашиг тус буюу сэтгэл дундуур биш үр дүнгүүд үлгэрлэвэл бүх тайлан тараалт нь тухайлбал байгаль орчны гаралтыг сонгож, нэг бүрийг харьцуулан стандартчилна.

А.1.4 Магадлуур(параметр)-ын урьдчилсан ангилалын талаархи жишээ

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрөөр илрэх, санал болгож буй магадлуурын бодиттой, урьдчилан гаргасан жишээ, жагсаалтын талаар бүрэн төгс биш байдлаар А.1 хүснэгтэд үзүүлсэн. Энэ жагсаалтыг байгаль орчын мэдэгдлийн III загварт зориулан хүлээн зөвшөөрсөн байдлаар ойлгож болохгүй.

Магадлуурын урьдчилсан ангилалын жишээ - А.1 дүгээр хүснэгт

АМНБ-ын дүн	АМНБҮ-ний өгөгдөл (дүнг заагч ангилал)	Цогцолбор үзүүлэлт	Сонголт-үнэлгээ
1. Эрчим хүчний зарцуулалт джоул/функционал нэгж	Нөөц баялаг	- Анх хэрэглэх эрчим хүч, - АМ-өөр,	Бүсийн ба шинж байдлын тархалтуудыг тэнцүү байдлаар авч үзэх
2. Усны зарцуулалт (м ³ /функционал нэгж)	Усны нөөц дуусах	- Усны бүх эх үүсвэр: (ө.х гадаргуугийн, гүний, давстай, давсгүй гэх мэт.) - АМ-өөр,	Усны бүх эх үүсвэрийг тэнцүү байдлаар авч үзэх Бүсийн ба шинж байдлын тархалтуудыг тэнцүү байдлаар авч үзэх
3. Нөхөн сэргээгдэхгүй нөөц (тн төмрийн хүдэр/функционал нэгж)	Эрдэсийн нөөц дуусах	Эрдэс нөөцийн эх үүсвэр. ө.х. янз бүрийн эрдэсүүд, АМ-өөр	Эрдэсийн нөөцийн бүх эх үүсвэрийг тэнцүү ач холбогдлоор авч үзэх. Бүсийн ба шинж байдлын тархалтуудыг тэнцүү байдлаар авч үзэх
4. Кадмий, мышьяк (мг/функционал нэгж)	Хүний эрүүл мэндэд хортой	Агаарт бодисууд зөөгдөн тархаж хавдар үүсгэх	Төгсгөлийн цэгт болон хортой бодисыг сонгох
SO _x кг/функционал нэгж	Хүчиллэгжүүлэлт	pH-д тулгуурласан эквивалент	Индикатор(заагч) нь болохыг мэдэгдэх

А. 2 АМНБ-ын дүнг задлан шинжлэх хувилбар аргазүй

А. 2.1 Ерөнхий зүйл

Энэ зүйлд байгаль орчны мэдэгдлийн III загварыг боловсруулж бэлтгэхэд АМНБ-ын дүнг задлан шинжлэх хувилбар аргазүйн холбогдолтой мэдээллээр хангана. Олон улсын хэмжээнд гарах дараачийн стандартад аливаа аргазүйг автоматаар дамжуулан энэ зүйлд оруулах шаардлагагүй.

MNS ISO/TR 14025 : 2001

Тэдгээрийг хэрэглэх болон арга зүйн хувьд гарах бусад зүйлийг байгаль орчны мэдэгдлийн III загвар нь техникийн хувьд хэрэгжих боломжтой стандарт уу, үгүй юу гэдгийг эх бичвэрийг зохиоходоо шийдвэрлэж, үнэлж байх болно. Байгаль орчны мэдэгдлийн III загвар нь нэмэлт мэдээллийг хувилбар байдлаар оруулж болно. А.2.7 нь ярилцлагын талаар зохих мэдээллийг оруулна.

Аргазүй бүрийг сайтар ярилцаж хангах, түүний тодорхойлолтыг оруулах, гаралтын холбогдол бүхий мэдээлэл, байгаль орчны мэдэгдлийн III загварын эх бичвэрийн аргыг хэд хэдэн үзүүлэн зургаар харуулсан бөгөөд цаашид судлах хэрэгтэй.

A.2.2 Аргазүйг сонгох шалгуур

Энэ зүйлд хувилбар аргазүйг тодорхойлсон ёсоор, хаана ч, дараахь ерөнхий шалгуурт үндэслэн сонголтыг хийнэ.

- арга зүй нь шинжлэх ухааны зөв хандлагатай, үндэслэл сайтай, олон талыг бодолцсон, байгаль орчны мэдэгдлийн III загварт нийцсэн, дэмжих боломжтой бөгөөд өндөр нарийвчлалтай, нөхөн үйлдвэрлэл(ISO 14020 : 1998, 4.4.1) байна.
- хэвлэмэл аргазүй нь шинжлэх ухааны салбарт хүлээн зөвшөөрсөн, хүлээн авах өргөн боломжтой, салбар шинжлэх ухааны үндэслэл сайтай(ISO 14020 : 1998, 4.4.2);
- практик ажиллагаанд мөрдөх бололцоотой байна.
- АМ нэг бүрийг хамарсан хандлагатайгаар, байгаль орчны талаархи АМНБҮ-ний дүнгийн холбогдлыг чанар чансаагаар үнэлсэн байх хэрэгтэй.

A.2.3 АМ-ийн стресс-үүсгэгч нөлөөг үнэлэх(АМСҮНҮ)

A.2.3.1 Тодорхойлон бичих

Амьдралын мөчлөг дэх[6], [7] өвөрмөц салбартай холбоо бүхий байгаль орчны өгөгдлийг нэгтгэснээр АМНБҮ-ний задлан шинжлэх стандартаар маш олон хязгаарлалт, тодорхой бус байдлыг АМСҮНҮ-ий холбогдол бүхий шинэ аргаар шийдвэрлэхэд чиглэнэ.

АМСҮНҮ, АМНБ-ын өгөгдөл бол цогцолбор бус, нэгтгээгүйг бас зөвшөөрнө, ингэхдээ тэр нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгт орчныг ганцаарчилан авах тохиолдолд нэлээд “хаалттай” зарчимд хамаарч байвал болно.

Заагчийн ангилал нь магадгүй, АМНБҮ-нд шаардах тохиромжтой орон зай ялгаруулалт(стресс-үүсгэгч)-ын хэмжилтийн байдал, үнэлгээний босгыг нэмэх ба байгаль орчинд(сөрөг нөлөө бүхий) төгсгөлийн цэгийн уялдааны дүүрэн эрчимтэй тохиромжит байдлыг тодорхойлох хэрэгтэй болсон. Тэдгээр өгөгдлийг заагчийн бүрэн, ангилсан тооцоонд шууд нэгтгэж хэрэглэнэ. АМНБҮ-нээс илүү байгаль орчны бодит нөлөөллийг урьдчилан хэлэхэд өвөрмөц онцлогтой тогтолцоо, байрлалд нь зориудаар хийх ба хамрах хүрээнд нь явуулах.

A. 1.3.2 Тогтолцооны зааг

АМСҮНҮ-ний зааг нь ISO 14040-д тодорхойлсон ёсоор, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шатыг байгаль орчны бохирдол ялгаруулалтыг мэдэж авах, эх үүсвэрээс олборлох хүрээлэлд зориулагдана.

А. 2.3.3 Өгөгдлийг цуглуулахад тавих шаардлага

Дээр дурдсанаар АМСҮНҮ-нд АМ-ийн өгөгдлийг цуглуулах үндэслэлийн хамрах хүрээнд АМНБ-ын цогцолбор бус өгөгдлийг хасдаг. Нэмэлт болгоход, байгаль орчинд бохирдол үүсгэх талаар холбогдох бодит нөлөөллийг мэдэж авах, түүний байгаль орчны төлөв байдал, орон зайн тухай өгөгдлийн хуримтлуулах хэлбэрийг ашиглана. Энэ бол материалын нөөцийн ашиглалтад мөн нэгэн адил хамаарна.

А. 2.3.4 Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан гаралт

АМНБҮ нь АМСҮНҮ-т заагчийн ангилалын цар хүрээг хангаж болох магадлалтай. Гэсэн хэдий ч, эдгээр заагчид нь АМНБ-ын өгөгдлийг цогцолбор болгоогүйг задлан шинжлэх явдлаас болж буй үйл явцыг тогтоож өгнө.

А. 2.3.5 Хязгаарлалт

Өгөгдөл цуглуулга ба АМСҮНҮ дэх удирдлага, зохицуулалт бол АМНБ буюу АМНБҮ-нээс илүү ач холбогдолтой. АМНБ –ын өгөгдөл нь үндсэндээ цогцолбор биш хэлбэртэй байна.

А. 2.4 Чигнэх(тэнсэх буюу жинлэх) арга

А. 2.4.1 Тодорхойлон бичих

АМНБҮ, АМНБ-ын судалгааны дүнг гаргахаар мэдэж буй хэд хэдэн хөтөлбөрүүд буюу АМ-ийн өгөгдөл, зэрэглэл, тэдгээрийг дэс дараалсан цогцолбор үзүүлэлтэд оруулан өөрчлөх, ач холбогдлоор нь жагсаах зэрэг төсөө бүхий хэлбэрүүд байна. Дадлагажигчтай холбогдуулан байгаль орчны гаралтын талаархи тэргүүлэх чиглэлд сонголт-үнэлгээгээр тэдгээр асуудалд итгэхэд бэрхтэй ч, гэсэн амьдралын мөчлөгийн өгөгдлийн тоон үзүүлэлтэд тулгуурладаг юм. ISO 14042 тоот стандартаар үнэлэх, чигнэх талаархи ашиглалт нь бүтээгдэхүүнийг хооронд нь харьцуулан хир хэмжээгээр нь батлан зөвшөөрч болохгүй. Ийнхүү, тэдгээр арга нь байгаль орчны холбогдолтой олон улсын эдгээр стандартын эко-тэмдэг хэрэглэх III загварт хамаарах гаралтын урсгал нь магадгүй хамаарч болно.

ISO 14042 стандартад тусгайлан тэмдэглэсэн зүйл бол “янз бүрийн байгууллага, этгээд олон янзын лавлагааны материалтай байж болно. Юуны өмнө, тэр бол боломжтой гэж янз бүрийн талуудаас үзэж, ижилхэн заагчийн дүнгээр буюу стандартчилсан заагчийн дүнд тулгуурлан янз бүрээр чигнэх явдал мөн. Швейцарийн “эко-цэг”-ийн болон Шведийн “байгаль орчны стратегийн гүйцэтгэлийн(БОСГ) тогтолцоог оролцуулан тогтолцооны чигнэх талаархи жишээ:

а) Швейцарийн эко-цэгийн тухай [9]

“ Эко-хүчин зүйл” буюу агаар, ус, хөрс/газрын гүний усны бохирдолыг янз бүрийн хүчин зүйлээр чигнэх, мөн эрчим хүчний нөөц, ашиглалтыг АМНБ-ын дүнд хэрэглэнэ. Задлан шинжлэх цэсийн үр дүнг тохирох чигнэлтийн хүчин зүйлээр, нэмэлтийн хамт

ба нэгдсэн нэг ерөнхий тооцоонд оруулна. Эко-хүчин зүйлүүд нь Швейцар дахь жилийн хамгийн их бөгөөд чухал тооцсон бохирдолын түвшин (Жилийн тайлангаарх инвентарийн урсгалд болон бохирдолын оргил үеийг нь авч үзнэ. Энэ оргил үеийн урсгал нь Швейцар Улсын байгаль орчны бодлого, зорилгыг шинжлэх ухааны талаас дэмжиж, дүгнэлт хийнэ.) Эрчим хүчний ашиглалт, эсвэл бохирдол ялгаруулалтаар байгаль орчны асуудал, холбогдол бүхий хортой бодисын тухай сонголт-үнэлгээг тодорхойлолтод багтаасан байна.

b) Байгаль орчны стратегийн тэргүүлэх чиглэл, БОСТЧ

Нөөц ашиглалтын болон бохирдол ялгаруулалтын төлөв байдал, орон зайн талаар мэдээлэл шаардлагатай гэж үздэг. Тэр ч байтугай, онцлог стресс-үүсгэгч нөлөөнд бодитой үр дүнд хүрэхийн тулд орчны онцлогийг мэдэж авах зорилготой нарийвчилсан өгөгдөл шаардлагатай байдаг. АМСҮНУ-ний үр дүн нь өгөгдлийг задлан шинжлэхтэй холбогдсон иж бүрэн томоохон үйл явц учраас өгөгдлийн тоогоор хэмжих бололцоогүй, эсвэл тодорхой бус байдлыг хангахгүй байж болно.

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрт одоогоор АМСҮНУ ашиглах санал болгосон бөгөөд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн боловсронгуй бус тогтолцоо, далд будлианыг хооронд нь харьцуулан авч үзэх үед үр дүнгүүд нь хааяа нэг утгатайгаар “зурвасын алдаа”-гүйг илэрхийлнэ.

Заагчийн ангилалын АМСҮНУ-ний жагсаалт нь АМНБ, АМНБҮ-тэй төсөөтэй, тэгэхдээ бүх ангилалууд нь байгаль орчны алсын бодлого талаас адил тэнцүү нь чухал юм. Заагч ангилалын дээд ач холбогдол нь байгаль орчиндоо бүхнээс чухал гэж эцсийн хэрэглэгчид, эсвэл бага утга нь байгаль орчинд холбогдол бага мэтээр буруу ташаа тайлбар өгөх явдал гардаг.

Дээр тэмдэглэсэн ёсоор, байгаль орчны мэдэгдлийн III загвараар бүтээгдэхүүнийг хооронд нь харьцуулах асуудал гарна гэж ойлговол зохино.

АМСҮНУ нь магадгүй, янз бүрийн бүтээгдэхүүнийг буюу байгаль орчны асуудлыг тодорхойлж буй заагчийн ангилалд үндэслэн шинжлэх ухааны талын нийтлэг шинжийг авч үзнэ.

АМ-ийн цэс нь үе шат бүрт үзүүлэх нөлөөтэй холбогдол бүхий үйл явц тогтвортой, эсэх тухай эдийн засгийн боломж хэрэгжилтийн ба өргөн дэлгэрүүлэх үндэслэлийн талаар ярилцлага хийж, шийдвэрлэж байна.

A. 2.3.6 Судалгааны хэрэгцээ

АМСҮНУ-ий судалгааг бүтээгдэхүүний холбогдолтой олон хязгаарлалтын тоог иж бүрдүүлсэн байна. Байгаль орчны мэдэгдлийн III загварын текстэд учир зүйн уялдааны аргазүйн тогтолцоог удирдан хөгжүүлэх үү, үгүй юу гэдэг талаар анхны судалгаа хэрэгтэй. Тийм загварчлалыг өргөн дэмжиж хөгжүүлэх, АМ-т холбогдолтой сөрөг нөлөөллийн үндэслэлийг нарийвчлан авч үзэх асуудал ч орно. Стресс-үзүүлэгч нөлөө бүхий асуудлыг боловсронгуй болгосны дараа, тогтолцооны хэмжээнд өгөгдлийг хэрхэн яаж дахин цогцолборт оруулах вэ гэдэг асуулт ч хааяа гардаг.

Швед Улсын энэ арга[10]-д ялгаруулалтын ачаалал ба нөөцийн ашиглалтыг нийтлэг нэгж (байгаль орчны ачааллын нэгж)–д төлөв байдлын болон чигнэх хүчин зүйл(байгаль орчны ачааллын индекс) хоёрыг хослуулан ашиглаж хувиргана. Тэдгээрийг хүснэгтэд оруулан индекс нэг бүрээр гаргаж, анх тайлагнахад, харин мөн цогцолбор болгох ба нэг тооцоонд оруулж багасгана.

БОСГ –ийн үр дүн нь онцлог инвентарь урсгал бүрт зориулсан байгаль орчны ачааллын индексийн хүснэгтүүдээс бүрдэнэ. Үүнд: Индекс бүр утгад –тулгуурлах

бөгөөд судлаачдын үзэл бодлоор сэдвийн аюулгүйн баталгаа сэдэв"-т төвлөрүүлж, хүний эрүүл мэнд, био-ялгаа, үйлдвэрлэл гэх мэт. Бохирдол ялгаруулалтын эрсдэлийн дундаж болон шүүгчийн шийдвэрт үндэслэнэ. Нэмэлт болгоход, индекс бүрт, хүчин зүйлийг боловсруулж, хохиролыг нөхөн төлөх "төлөх бэлэн байдал" буюу "бохирдуулбал төлбөр төлөх зарчим"-тай байхаар өөрчилнө. Үр дүнгүүдийг мөнгөн тоогоор тайлагнах нь зүйтэй.

А. 2.4.2 Хязгаарлалт

Дээр дурдсан АМНБ-д зориулан тодорхойлсон хязгаарлалт нь чигнэх талаархи бүх хөтөлбөрт хэрэглэнэ. Нэмэлт болгоход, байгаль орчны янз бүрийн үүрэг ачааны хамаарах ач холбогдлын тухай сонгосон-үнэлгээний суурь үзүүлэлт нэг бүрийг эдгээр аргад оруулж тусгасан байна.

Тэдгээр нь байгаль орчны текстэд янз бүрийн өгөгдлийн цэсийн тухай хэрхэн яаж илэрхийлэх болон хөрвүүлэхэд мөн хааяа хамаарал бүхий хэд хэдэн шийдвэр байна.

А. 2.4.3 Судалгааны хэрэгцээ

Байгаль орчны мэдэгдлийн текстэд ойлгомжтой байдлын тухай чигнэх бүх тогтолцоотой холбогдуулан АМНБ, АМНБҮ-нд зориулсан судалгааг тэр тал руу тэмдэглэнэ. Судалгаатай холбогдуулан үнэлэмжийг эцсийн хэрэглэгчид хэрхэн яаж тайлбарлах ба сонгосон-утга нь хөтөлбөртэй хэрхэн холбогдох, шүүмж гаргахын өмнө байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрт техникийн аргыг нь стандартчилсан байвал зохино.

А. 2.5 Амьдралын мөчлөгийн менежмент(удирдлага) -АММ

А. 2.5.1 Тодорхойлон бичих

АММ гэдэг нь үйлдвэрлэлийн явц эсвэл байгаль орчны бүтээгдэхүүнтэй холбогдолтой асуудлыг авч үзсний ачаар эдийн засгийн зохистой өртөг зардлыг тулгаж харьцуулах, тодорхойлохоор амьдралын мөчлөгийг задлан шинжлэх ажиллагааг хэлнэ. АММ бол үйл явц буюу бүтээгдэхүүнийг тулгаж харьцуулахтай холбогдолтой маяг хэлбэр юм.

Тэрхүү олон улсын стандарт боловсруулах төвлөрөл нь үйлдвэрлэлийн арга хэрэгслийг байгаль орчны тогтолцооны адилаар ажиллагсдыг судлах ажлыг хааяа хийж, асуудлыг тухай бүр нь авч үзнэ.

АММ нь задлан шинжлэх уламжлалт зардлыг шууд бус нэмүү өртөг зардалтай нь, байгаль орчны бохирдол, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдал, дахин боловсруулж ашиглах, бүтээгдэхүүний эцсийн хог хаягдлыг хамтад нь цогцоор авч үзнэ. Энэ хандлага нь байгаль орчны мэдэгдлийн III загварыг хэрэглэгч-үйлдвэрийнхэнд тохиромжтой байх боловч, харилцаа холбоо бүхий хэрэглэгчид төдийлэн хэрэглэгдэхгүй юм.

А. 2.5.2 Тогтолцооны зааг

АММ бол бизнес-үйлдвэрлэлийн ажиллагаа, хэрэглэгчдийн ашиглалт болон хог хаягдал тэдгээрийн байгаль орчинд хамаарах төгсгөлийн цэгт төвлөрнө. Цэгийн эхлэл нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл явц болон түүхий эд материал, эсвэл

MNS ISO/TR 14025 : 2001

ашиглах нөөцийг үйлдвэрлэлд ердийн хэлбэрээр эргүүлэн татах бололцоогүй ажиллагаанаас эхэлдэг.

А. 2.5.3 Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан гаралтын суваг

АММ –ийн үр дүн бол ер нь бүтээгдэхүүний холбогдолтой эдийн засгийн өртөг зардлыг нэгтгэсэн байдлаар илэрхийлдэг. Тэдгээрийг цогцолбор шинжтэйгээр эсвэл өртөг зардалтай хамтад нь эцсийн онцлогтой нь холбогдуулан тус тусад нь тайлан гаргана. Зарим бүтээгдэхүүний функционал нэгжид зохистой үнэ өртгийг илэрхийлдэг(ө.х. үйлдвэрлэсэн 1000 ширхэг нэгж нь 1 ам. доллар)

А. 2.5.4 Өгөгдлийг цуглуулахад тавих шаардлага

Онцгой үйлдвэрлэлийн үйл явц, түүний нийт зардал дээр хэрэглэгчийн ашиглалтын үед гарах болон хог хаягдлыг бөөгнөрүүлэхтэй холбогдсон нийт өртөг зардлын мэдээллийг цуглуулах хэрэгтэй байдаг. Бүтээгдэхүүн, үйл явцыг хувилбар байдлаар өгөгдөл(мэдээлэл/тодорхойлолт)-ийг харьцуулах зорилгоор ашиглагдах асуудалд нь төсөө бүхий ангилалыг цуглуулж болно.

А. 2.5.5. Хязгаарлалт

АММ-тэд АМНБҮ-тэй нэгтгэж, ижил төсөө бүхий олон хязгаарлалтыг хэрэглэх бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний бодит дутагдал, өгөгдлийн тодорхой бус байдал, янз бүрийн бүтээгдэхүүний заагийн өөрчлөмтгий байдал гэх мэт. Нэмэлт болгоход, АММ бол эдийн засгийн томъёололд оруулахаар байгаль орчинд хамаарах үүрэг ачааг хөрвүүлэх оролдлого юм. Ижил төсөө бүхий зарим технологийн төгсгөлийн цэгийн арга хэмжээг, тухайлбал бохир усны хуримтлал, мэдэгдлийн холбогдолтой өртөг зардлыг нэг мөр зүгшрүүлэх явдал юм. Гэсэн хэдий ч, бусад онцгой тохиолдолд тэдгээр үйлдвэрлэгчид руу хяналт тавих, эсвэл(өөрсдөө бүтээгдэхүүний бохирдолоо зайлуулахтай) холбогдсон зардлаа бага гэсэн ойлгомжтой тодорхойлох бөгөөд сонгосон-үнэлгээ шаардлагатай байна. Эдгээр санал шүүмжийг хэлэлцэх үед байгаль орчинд хамаарах асуудлаар бүтээгдэхүүний хувьд зөвхөн нэг байдлаас нөгөөд янз бүр болж өөрчлөгдөх, цаашилбал байгаль орчны мэдэгдлийн III загварын эх бичвэр(текст)-т оруулахаар харьцуулалт хийхэд төвөг учруулах талтай.

А. 2.5.6 Судалгааны хэрэгцээ

Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан АММ–ийн тэргүүлэх ач холбогдлыг авч үзэхэд байгаль орчны онцгойлох цэгийн холбогдолтой дан ганц бизнесийн ажиллагааны зардлын өгөгдлийг хуримтлуулах талаархи онцлог хүчин зүйлийг үйлдвэрүүд хөгжүүлэх шаардлагатай. Нэмэлт болгоход, задлан шинжилгээний үр дүнг тайлбарлах, ялангуяа байгаль орчны мэдээлэлд шууд холбогдох эдийн засгийн тэдгээр тоймыг эцсийн хэрэглэгчээс зөв ойлгоход судалгаа хэрэгцээтэй байдаг.

А. 2.6 Байгаль орчны байгууламж, эдийн засгийн дэмжлэг(БОБЭЗД) үзүүлэх арга

А. 2.6.1 Тодорхойлон бичих

БОБЭЗД [11] бүтээгдэхүүний амьдралын мөчлөгөөр оруулах туршид олон хэмжээст хандлагыг байгаль орчны нөлөөлөл болон эдийн засгийн асуудалтай авч үзэж, шийдвэрлэх аргазүйтэй байна. Гэхдээ, түүний гол хэрэглэгдэх зүйл бол байгууламж, бүтээгдэхүүний бүтэц найрлага, үзэл баримтлал нь өөр бусад олон бүтээгдэхүүнд хэрэглэгдэх боломжтой.

БОБЭЗД-ийн байгаль орчинд хамаарах амьдралын мөчлөгийн хэсгийн хандлага нь ISO 14040 тоот стандартад заасны дагуу АМНБҮ нь дараахь байдлаар тэмдэглэсэн байна. Энэ нь ASTM¹-аас амьдрал мөчлөгийн эдийн засгийн гүйцэтгэл үзүүлэлтийг тооцох(LCC) аргачлал[14]-ыг ашилавал зохино. Түүнийг “[BEES буюу БОБЭЗД] арга” гэж тэмдэглэдэг бөгөөд энэ талаар олон улсын стандартад гол анхаарлаа төвлөрүүлээгүй байсан. Гэвч, ажиллагсад урьдал болгон хааяа түүнийг байгаль орчны тогтолцоог задлан шинжлэх арга хэрэгсэл болгож, үйлдвэрлэлтэй холбогдсон судалгаа байгууламжид хэрэглэдэг юм.

А. 2.6.2 Тогтолцооны зааг

БОБЭЗД аргазүйд, тогтолцооны зааг нь тэдгээртэй ижил төсөөтэй гэж АМНБҮ, ISO 14040 цувралын стандартад тэмдэглэсэн байна.

А. 2.6.3 Байгаль орчны мэдэгдлийн III загварт зориулсан гаралтын суваг

БОБЭЗД үзүүлэх аргын үр дүнгийн хандлага нь байгаль орчинд хамаарах цогцолбор болон холбогдох өртөг зардлын цогц асуудал хоёуланг хамтад нь эсвэл салангид нь илэрхийлнэ. Хэрвээ хамтад нь авч үзвэл, чигнэх эгнээг хааяа өгөгдөлд нь хэрэглэнэ. Тэдгээр эгнээ нь сонголт-үнэлгээний аргад тулгуурлана. Бүтээгдэхүүний харьцуулалт(ө. х. 100 ам метр шал бүтээх)-ыг хөнгөлөхөөр функционал нэгжид холбогдлыг нь илэрхийлж байна.

А. 2.6.4 Өгөгдлийг цуглуулахад тавих шаардлага

БОБЭЗД үзүүлэх арга нь АМНБҮ-нд тавих өгөгдлийн шаардлагатай адилаар илрэх бөгөөд эдийн засаг / өртөг зардлын бүрэлдэхүүн ингэхдээ зөвхөн анхны хөрөнгө, материалын зардал төдийгүй, үндсэн ба орлуулах материалын зардал гэх мэт. бүтээгдэхүүний тогтолцооны байгууламжийг нэмж оруулах нь найдвартай.

А. 2.6.5 Хязгаарлалт

Дээр заасан АММ –ийн аргазүйтэй хязгаарлалтыг нэгтгэж, олонхи тохиолдолд БОБЭЗД үзүүлэх аргазүйд зааж, чиглүүлнэ. Нэмэлт болгоход, БОБЭЗД үзүүлэх аргазүйн иж бүрэн тайлбарлалт, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг бүрэн задлан шинжлэх цэс, түүнчлэн АМНБ-ын холбогдол бүхий хязгаарлалт нь ач холбогдолтой.

А. 2.6.6 Судалгааны хэрэгцээ

БОБЭЗД үзүүлэх аргазүйн тэргүүлэх чиглэлд бүх судалгааг тодорхойлж хэрэглэнэ. Нэмэлт болгоход, хэрэгцээт судалгаанд зориулан олон тооцоотой их зүйлийг урьдчилан харж илрүүлэх бөгөөд байгаль орчны мэдэгдлийн III загвараар түүний өртөг зардлыг саатуулахаар шууд, илэрхий бус зорилготой, тэдгээрийг мэдээлэлд оруулж хөрвүүлэн хувиргахыг авч үзэж болно.

A. 2.6.7 Байгаль орчны нэмэлт мэдээлэл

A. 2.6.7.1 Тодорхойлон бичих

Хэрэглэгч, боломжтой худалдан авагч, худалдагч нарт зориулан тодорхой бүтээгдэхүүнд байгаль орчны мэдэгдэл хэрэглэж, баримтад тусгах мэдээлэл агуулж байна. Ерөнхийдээ, байгаль орчны нэмэлт мэдээлэлд онцлог бүтээгдэхүүний ашиглалтад холбогдох байгаль орчны мэдээлэл, хадгалалт, хог хаягдал, эсвэл хэрэглээнд дасаагүй бүтээгдэхүүнийг дахин хэсэглэн савлах, сав/чингэлэг, сав боодлын материал[13]-ыг оруулна. Мөн мэдүүлэгийг нэгдсэн дансанд оруулах талаар байгаль орчны нэмэлт мэдээллийн зарим жишээ:

- аюулгүй ашиглалтад зориулан урьдчилсан анхааруулга, болгоомжлол,
- үр дүнтэй хэрэглэхтэй холбогдсон заавар, эсвэл бүтээгдэхүүнд төрөлхийн байдаг шинж чанар, ашигтай талын тухай мэдээлэл,
1)
ASTM- Америкийн материал, туршилтын стандартын нийгэмлэг
- бүтээгдэхүүн ашиглахтай холбогдож, боломж бүхий хортой хог хаягдал,
- бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох мэдээлэл(ө.х. нэр, үйлдэл, тоо хэмжээ, химийн үзүүлэлт, хоруу чанар гэх.мэт)
- онцгой хог хаягдлын зааварчлага буюу чингэлэг эсвэл уг бүтээгдэхүүний хэрэглээнд дасаагүй талаархи мэдүүлэг,
- озоны давхаргыг нимгэлэх, улмаар цоолох химийн бодисгүй, эсвэл (CFC-гүй) эсвэл (CFC) хлоржсон төмөрт нүүрстөрөгчийн агуулгатай тус тус холбогдуулан байгаль орчинд хамаарах онцлог бусад мэдээлэл орно.

A. 2.7.2 Байгаль орчны нэмэлт мэдээлэлд зориулсан судалгааны хэрэгцээ

Хэрэглэгч, худалдан авагч, боломжтой худалдагчид танилцуулах зорилгоор бүтээгдэхүүнтэй холбогдуулан байгаль орчны онцлог мэдээллийг олгоно. Уг бүтээгдэхүүний ашиглалт, хаягдал ажиллагааны туршид эцсийн хэрэглэгчээс хааяа заримдаа байгаль орчны тухай дансанд оруулан бичсэнийг уншиж ойлгож, чаддаггүй. Эцсийн хэрэглэгч мэргэжлийн ач холбогдолтой байгаль орчны талаар дансанд бичсэнийг зөвхөн сонгон шалгаруулан мэдэж авах хувилбар гаргадаг явдал бий. Түүнээс гадна, байгаль орчны янз бүрийн хосолмол хувилбар, бүтээгдэхүүнийг дансанд бичих талаар сонголт-үнэлгээний цорын ганцхан давтагдашгүй хувилбар байхыг үгүйсгэхгүй.

Цаашид энэ асуудлын хүрээнд байгаль орчны мэдэгдлийн III загварын ашиг тусыг, мөн түүнчлэн байгаль орчны эко-тэмдгийн холбогдолтой бусад мэдээллийг батлах судалгааг хийж болно.

В. Хавсралт (зөвлөмжийн шинжтэй)

Байгаль орчны мэдэгдлийн III загварын хөтөлбөрт оролцох
байгууллагын үүрэг ролийн талаархи жишээ

Хөтөлбөрийн хэлбэр	Оролцогч талууд			
	Мэдэгдэл авах	Мэдэгдэл, хөтөлбөр, журмын боловсруулалт, үндсэн бүтэц	Шүүмжийг хөтлөн явуулах	Тухайн мэдэгдэл дүрэм, журмын шаардлагатай тохирч байгааг баталгаажуулах эсэх
Хөтөлбөргүй баталгаажуулалт	Компани буюу байгууллага	Компани буюу байгууллага	Бие даасан шүүмжлэгч	Хэрэглэхгүй
Хөтөлбөргүй баталгаажуулалт	Компани буюу байгууллага	Хувийн буюу олон нийтийн байгууллага (ө.х. үйлдвэрлэлийн нийгэмлэг, хөндлөнгийн дадлагажигч этгээд, эрх бүхий байгууллага)	Бие даасан шүүмжлэгч (ижил төсөөтэй хөтөлбөр гаргагч байж болох)	Баталгаажуулалтын байгууллага (ижил төсөөтэй хөтөлбөр гаргагч байж болох)
Хөтөлбөргүй баталгаажуулалт	Компани буюу байгууллага	Хувийн буюу олон нийтийн байгууллага (ө.х. үйлдвэрлэлийн нийгэмлэг, Дадлагажигч хөндлөнгийн этгээд, Эрх мэдэл бүхий байгууллага)	Бие даасан шүүмжлэгч (ижил төсөөтэй хөтөлбөр гаргагч байж болох)	Итгэмжилсэн баталгаажуулалтын байгууллага

Ганц компанитай тохиолдолд амьдралын мөчлөг нь байгаль орчны мэдэгдэлд үндэслэгдэнэ.

Ганц компани	Компани буюу байгууллага	Компани буюу байгууллага	Бие даасан шүүмжлэгч	Хэрэглэхгүй
а Өнөөдөр зарим нэгэн ганц компанид мэдэгдлийн шинж байдлыг харгалзан хөгжүүлж байгаа боловч, тэдгээр хандлага нь хөндлөнгийн этгээдийн оролцоо буюу секторын ажлын дутагдалд үндэслэсэн тул байгаль орчны мэдэгдлийн III загвар шиг шийдвэрлэх боломжгүй юм.				

Ном зүйн мэдээлэл

- [1] ISO 14001 : 1996, Environmental management systems-Specification guidance with use.
- [2] ISO/TR 140472, Environmental management-Life cycle assessment –Example of application of ISO 14042,
- [3] ISO 14048 2, Environmental management-Life cycle assessment –Life cycle assessment data documentation format,
- [4] ISO 14048 2, Environmental management-Life cycle assessment –Example of application of ISO 14041 to goal and scope definition and inventory analysis,
- [5] ISO/IEC Guide 2: 1996, Standardization and related activities-General vocabulary.
- [6] Life Cycle Sressor Effects Assessment(LCSEA) –ISO TC 207/SC3/WG1/TG Type III, N22, Annex 1 rev.,
- [7] Appenix 1, Wood in our Future, Proceedings of a Symposim, National Reseach Council, National Academy Press, Washington D.C., 1997.
- [8] HEIJUNGS, R., et al., Environmental management-Life cycle assessment of products: Guide and background –2 volumes-CML University of Leiden. The Nederlands, 1992.
- [9] Brand, G., et al., Method of eco-scacity-Ecofactors , 1997. Swiss Agency for the Environment , Forest and Landscape. Environment Series No. 297. Bern, 1999.
- [10] STEEN.B., EPS-default valuation of environmental impacts from emission and use of resources. Version 1996, Swedish Environmental and Protection Agency, AFR report 111, 1996.
- [11] Building for Environmental and Economic Sustainability, the BEES Method of the NTIS.
- [12] Environmental Information Pofile Data Sheet, Canadian Pulp and Paper Association.
- [13] WINTERS, J.,EPA 742-R-98-009, 1998, Environmental labelling-Issues, Policies, and Practices Worlwide.
- [14] ASTM E917-9: 1994, Practice for measuring life-cycle costs of buildings and building systems